



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ 2016 - II УЛИРАЛ



## АГУУЛГА

БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ ТОЙМ	6
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	8
БҮЛЭГ 3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ	10
3.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	10
3.1.1. Зах зээлийн үнэлгээ	10
3.1.2. Үнэт цаасны зах зээлийн индексүүд	12
3.2. ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД	13
3.3. ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ	17
3.3.1. Хувьцааны арилжаа	18
3.3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа	19
3.3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	20
3.3.4. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаа	20
3.4. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ	21
3.5. ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	22
3.5.1. Үнэт цаасны арилжааны мөнгөн гүйлгээ	22
3.5.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд	23
3.6. ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ	23
3.6.1. Төрийн зохицуулалт, хяналтын орчин	23
3.6.2. Үнэт цаасны зах зээлийн бодлого, зохицуулалт	24
3.6.3. Хяналт шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	25
БҮЛЭГ 4. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	27
4.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	27
4.1.1. Үйл ажиллагааны үзүүлэлтүүд	27
4.1.2. Даатгалын үйлчилгээний хүртээмж	28
4.1.3. Даатгалын гүнзгийрэлт	30
4.2. САЛБАРЫН БҮТЭЦ, ҮЙЛ ХӨДЛӨЛ	31
4.2.1. Салбарын бүтэц	31
4.2.2. Салбарын үйл хөдлөл	32
4.2.3. Даатгалын салбарын гүйцэтгэл	32
4.3. ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ	34
4.3.1. Салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчин	34
4.3.2. Даатгуулагчдын эрх ашгийн хамгаалалт	34
4.3.3. Хяналт, шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга, хэмжээ	34
БҮЛЭГ 5. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	36
5.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	36
5.2. ББСБ-УУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	38
5.2.1. Зээл	38
5.2.2. Гадаад валютын арилжаа	39
5.2.3. ББСБ-уудаас үзүүлж буй бусад үйлчилгээ	39
5.3. АШИГТ АЖИЛЛАГАА	40
5.3.1. Орлогын бүтэц	41
5.3.2. Зарлагын бүтэц	41
5.4. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	42
5.4.1. Валют арилжааны ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	42
5.4.2. Зээл санхүүжилтийн ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	43
5.4.3. Хөрөнгө удирдлагын ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	43
БҮЛЭГ 6. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	44
6.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	44
6.2. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	47
6.3. ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ	47
6.3.1. Салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчин	47
6.3.2. Салбарын бодлого	47
БҮЛЭГ 7. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН	48

## ДҮРСЛЭЛ

- Дүрслэл 1. Гадаад худалдааны нийт эргэлт (он тус бүрийн эхний хагас жилд, сая ам.доллар)
- Дүрслэл 2: Гадаад худалдааны тэнцэл (он тус бүрийн эхний хагас жилийн байдлаар, сая ам.доллар)
- Дүрслэл 3. Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)
- Дүрслэл 4. ДНБ/ЗЗҮ
- Дүрслэл 5. ТОП-20 индекс
- Дүрслэл 6. Хувьцаат компанийн тоо
- Дүрслэл 7. Нийт үнэт цаасны арилжааны бүтэц (хувиар)
- Дүрслэл 8. Хувьцааны арилжаа
- Дүрслэл 9. Шинээр болон нэмж үнэт цаас гаргагчдын тоо
- Дүрслэл 10. ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа
- Дүрслэл 11. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо
- Дүрслэл 12. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь
- Дүрслэл 13. Үнэт цаасны зохицуулалтын бодлого (IOSCO)
- Дүрслэл 14. Ердийн ба урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгө (тэрбум төгрөг)
- Дүрслэл 15. Ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын хураамжийн орлого (тэрбум төгрөг)
- Дүрслэл 16. Давхар даатгалд төлсөн хураамж
- Дүрслэл 17. Даатгалын нягтрал (төгрөгөөр)
- Дүрслэл 18. Даатгалын компани болон зуучлагчийн салбаруудын байршил
- Дүрслэл 19. Ердийн даатгалын компанийн зах зээлд эзлэх хувь
- Дүрслэл 20. Ердийн даатгалын компаниудын борлуулалт, маркетингийн зардал
- Дүрслэл 21. ББСБ-уудын тоо
- Дүрслэл 22. Нийт актив ба ДНБ
- Дүрслэл 23. Нэг ББСБ-д ногдох хүн амын болон ААН-ийн тоо
- Дүрслэл 24. Ашигт ажиллагаа
- Дүрслэл 25. Нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгийн өгөөж
- Дүрслэл 26. Хүүгийн ба хүүгийн бус орлого
- Дүрслэл 27. Зардлын бүтэц
- Дүрслэл 28. Хадгаламж, зээлийн хоршоодын актив (тэрбум төгрөг)
- Дүрслэл 29. ХЗХ-дын нийт зээлийн чанар (тэрбум төгрөг)
- Дүрслэл 30. ХЗХ-дын нийт хадгаламж (тэрбум төгрөг)
- Дүрслэл 31. ХЗХ-дын өөрийн хөрөнгө, өр төлбөр (тэрбум төгрөг)
- Дүрслэл 32. ХЗХ-дын тоо (тэрбум төгрөг)
- Дүрслэл 33. ХЗХ-дын ашигт ажиллагаа
- Дүрслэл 34. Батлан даалтын тоо
- Дүрслэл 35. Батлан даалтын хэмжээ (тэрбум төгрөг)

## ХҮСНЭГТ

- Хүснэгт 1. Индексийн өгөөж
- Хүснэгт 2. 2016 оны эхний хагас жилийн бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)
- Хүснэгт 3. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани
- Хүснэгт 4. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо
- Хүснэгт 5. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц
- Хүснэгт 6. Ногдол ашиг тараасан хувьцаат компани
- Хүснэгт 7. Зохицуулалттай этгээдийн тоо
- Хүснэгт 8. Арилжаанд эзлэх хувь
- Хүснэгт 9. Нийт хөрөнгө (төгрөгөөр)
- Хүснэгт 10. Нийт орлого (төгрөгөөр)
- Хүснэгт 11. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт
- Хүснэгт 12. Шинээр болон нэмж үнэт цаас гаргагчдын мэдээлэл (төгрөгөөр)
- Хүснэгт 13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (тэрбум төгрөг)
- Хүснэгт 14. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ
- Хүснэгт 15. Мөнгөн гүйлгээний задаргаа (сая төгрөг)
- Хүснэгт 16. Санхүүгийн зах зээлийн хяналтын бүтэц
- Хүснэгт 17. Даатгалын гүнзгийрэлт
- Хүснэгт 18. Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид
- Хүснэгт 19. Ашигт ажиллагаа
- Хүснэгт 20. Даатгалын салбарын зардлын харьцаа
- Хүснэгт 21. ББСБ-уудын санхүүгийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)
- Хүснэгт 22. ББСБ-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Хүснэгт 23. Зээлийн бүтэц
- Хүснэгт 24. Богино хугацаат хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)
- Хүснэгт 25. Валют арилжааны зохистой харьцаа
- Хүснэгт 26. Зээл санхүүжилтийн зохистой харьцаа
- Хүснэгт 27. Хөрөнгө удирдлагын зохистой харьцаа
- Хүснэгт 28. Зохистой харьцаа
- Хүснэгт 29. Олгосон батлан даалтын тоо, хэмжээ

## БҮЛЭГ 1

# ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ ТОЙМ

Олон улсын хөрөнгийн зах зээл дээр сүүлийн улирлуудад хувьцааны ханш буурах хандлагатай байсан хэдий ч 2016 оны 2 дугаар улиралд бага зэрэг өслөө.

Их Британи улс Европын холбооноос гарахаа мэдэгдсэнтэй холбогдуулан хөрөнгийн зах зээл дээр хувьцааны ханш огцом унаж, эргээд хэвийн байдалд орж байна.

Хүснэгт 1. Индексийн өгөөж (хувиар)

Индекс	2016 оны 6 дугаар сар		2016 оны 2 дугаар улирал		2016 оны эхний хагас жил	
	АНУ-ын доллар	Тухайн орны валют	АНУ-ын доллар	Тухайн орны валют	АНУ-ын доллар	Тухайн орны валют
MSCI World	-1.1	-1.3	1.0	1.3	0.7	-0.7
MSCI EAFE	-3.4	-3.8	-1.5	-0.7	-4.4	-7.2
MSCI EMIMI	3.8	1.5	0.6	0.7	5.7	2.9
MSCI Europe	-4.4	-2.0	-2.7	1.2	-5.1	-3.7
MSCI Pacific ex Japan	0.8	-1.2	0.7	2.6	2.5	0.5
S&P 500	0.3	0.3	2.5	2.5	3.8	3.8
MSCI Japan	-2.5	-9.8	1.0	-7.8	-5.6	-19.5
MSCI UK	-3.6	5.0	-0.7	6.7	-3.1	6.9
Barclays Global Aggregate index	2.9	-	2.9	-	9.0	-
Barclays U.S. Aggregate index	1.8	1.8	2.2	2.2	5.3	5.3
J.P. Morgan EMBI Global	3.7	3.7	5.4	5.4	10.9	10.9
J.P. Morgan GBI-EM Global diversified	5.9	2.4	2.7	3.2	14.0	8.3

Эх үүсвэр: <https://www.thecapitalgroup.com>

**Хойд Америк:** Европын холбооноос Их Британи улс гарахтай холбоотойгоор АНУ-ын хувьцааны зах зээлд тодорхойгүй байдал үүссэн ч өсөлттэй гарлаа. Тухайлбал, Стандарт энд пүүрс 500 индекс 2 хувиар, Доу Жонс 2 хувиар өсч, Насдак индекс хэвийн түвшинд байв. Тайлант улиралд хөрөнгө оруулагчид эрсдэл багатай буюу харилцаа холбоо болон хангамжийн салбарт түлхүү хөрөнгө оруулж, эдгээр салбарын өсөлт 7 хувьд хүрсэн. Харин мэдээллийн технологийн салбарын дээрх үзүүлэлт 4 хувиар буурсан.

Тухайн улиралд газрын тосны фьючерсийн арилжаа идэвхтэй байж 25 хувиар өсч, нэг баррель нь 48 ам.доллараас давав. Бусад эрчим хүчний бараа, түүхий эдийн арилжаа мөн өсөлттэй байлаа.

АНУ-д компаниудын нэгдэх, нийлэх үйл ажиллагаа идэвхжив. Тухайлбал, Майкрософт компани нийгмийн сүлжээний бизнес эрхлэгч "Линкедин"-ийг 26 тэрбум ам.доллараар худалдан авлаа. Холбооны нөөцийн банк 6 дугаар сарын хурлаар нөөцийн зорилтот хэмжээг 0.25-0.5 хувьд барих шийдвэр гаргав.

Бондын зах зээлд Баркли Юу.Эс агрегат индекс 2.2 хувиар өссөн бол Засгийн газрын 10 жилийн хугацаатай өрийн бичгийн өгөөж 29 хувиар буурч, 1.49 хувь болсон байна. Улс төрийн болон эдийн засгийн тодорхойгүй байдал нь улирлын хэлбэлзлийг улам их өсгөх хүчин зүйл болж байна. Корпорацийн бонд 3.6 хувиар өсч, татвараас чөлөөлөгдөх нөхцөлтэй бонд 2.6 хувийн, корпорацийн өндөр өгөөжтэй бонд 5.5 хувийн ашигтай байв.

**Европ:** Англичууд Европын холбооноос гарах тухай санал хураалтын дүн гарч, уг холбооны тогтвортой байдал хадгалагдах эсэх, эдийн засгийн уналтын хэмжээ ямар байх талаар асуултууд гарч ирсэнтэй холбоотой Европын хөрөнгийн зах зээл дээр хувьцааны ханш унасан ч зарим алдагдлуудыг хасвал улирлын сүүлийн хоногуудад хөрөнгийн зах зээл эргэн сэргэж, Эм-Эс-Си-Ай индекс нэг хувиар өсөв.

Европын засгийн газрын бондын хүү буурах хүлээлттэй байсны дагуу Германы 10 жилийн хугацаатай өрийн бичгийн өгөөж түүхэндээ анх удаа буурснаар улирлын эцэст -0.13 хувьд хүрэв. Их Британи улс Европын холбооноос гарсны дараа “Стандарт энд пүүрс” компани тус улсын зээлжих зэрэглэлийг улс төр, эдийн засгийн тогтворгүй байдлын улмаас “AAA” үнэлгээг 2 нэгжээр бууруулж “A” болгосон байна.

**Япон:** Энэ оны 2 дугаар улиралд Ази-Номхон далайн хөгжингүй орнуудын үнэт цаасны зах зээл дундаас Япон улсынх хамгийн бага өгөөжтэй байлаа. Европ дахь геополитикийн эрсдэл хувьцааны өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж тус улсын Эм-Эс-Си-Ай индекс 8 хувиар буурсан. Гэхдээ Япон улсын эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас өссөн ч улсын инфляци 5 дугаар сард 2015 онтой харьцуулахад 0.4 хувиар буурсан. Энэ нь Төв банкны таамаглалаас 2-оос илүү хувиар зөржээ.

**Австрали:** Тус улсын үнэт цаасны зах зээл дээр металлын болон уул уурхайн компаниудын хувьцааны ханшийн өсөлт тэргүүлэв. Энэ нь Ньюкрест Майнинг компанийн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, өртөг буурсан тухай зарласны дараа хувьцааны ханш 36 хувиар өссөн бол, Би-Эйч-Пи Биллитон, Рио Тинто, Фортескью зэрэг металлын компаниудын хувьцааны ханш өсөхөд бараа, түүхий эдийн зах зээл дээрх үнэ өссөнтэй холбоотой хувьцааны ханш өсчээ. Энэ оны 5 дугаар сард Австралийн төв банк бэлэн мөнгөний хэмжээг 1.75 хувиар бууруулсан нь Австрали долларын ханш АНУ-ын долларын эсрэг 3 хувиар сулрахад нөлөөлсөн байна.

**Хөгжиж буй зах зээлтэй орнууд:** Хөгжиж буй зах зээлтэй орнуудын Эм-Эс-Си-Ай индекс нэг хувиар өслөө.

## БҮЛЭГ 2

# МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

**Дотоодын нийт бүтээгдэхүүн:** Эдийн засгийн бодит өсөлт 2014 онд 7.8 хувь, 2015 онд 2.3 хувь байсан бол 2016 оны 2 дугаар улирлын байдлаар оны эхэн үетэй харьцуулахад 1.4 хувь, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.1 хувиар өссөн байна. Үүнд уул уурхайн салбар 9.1 хувь, хөдөө аж

ахуйн салбар 3.5 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ. Харин боловсруулах үйлдвэрлэл 12 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 7.5 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. 2016 оны эхний хагас жилийн бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)

№	Бодит ДНБ	Салбарын өсөлт	Өсөлтөд эзлэх хувь (100%)
1	Хөдөө аж ахуй	0.5%	38.4%
2	Уул уурхай, олборлолт	2.0%	146.7%
3	Боловсруулах үйлдвэрлэл	-0.7%	-48.3%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1%	7.0%
5	Барилга	0.0%	-0.1%
6	Бөөний болон жижиглэх худалдаа	0.0%	1.6%
7	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.1%	4.6%
8	Мэдээлэл, холбоо	0.1%	4.6%
9	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.1%	8.1%
10	Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.8%	-62.4%


Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

**Инфляци:** Монгол Улсын жилийн инфляци 2014 оны 8 дугаар сараас үргэлжлэн буурч байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулсан үнэ тогтворжуулах хөтөлбөрийн эерэг нөлөөтэй холбоотой юм. Харин энэ оны 6 дугаар сарын байдлаар 1.6 хувьтай болж өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 5.7 нэгж, өмнөх сартай харьцуулахад 0.2 нэгжээр бага гарсан нь эдийн засгийн удаашралтай холбоотой байна.


**Гадаад худалдаа:** 2011-2013 онд жил бүр дунджаар 2 тэрбум ам.долларын алдагдалтай гарч байсан бол 2014 онд 539.0 сая, 2015 онд 882.0 сая ам.долларын илүүдэлтэй байлаа. 2016 оны 2 дугаар улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл 698.0 сая ам.долларын илүүдэлтэй байна. Сүүлийн 2 жил гадаад худалдааны тэнцэл илүүдэлтэй гарч байгаа боловч нийт эргэлт буурах хандлагатай байна. Тухайлбал гадаад худалдааны нийт эргэлт 2011 онд 11,415.0 сая ам.доллар байсан бол 2015 оны жилийн эцсийн байдлаар 8,466.0 сая ам.доллар болж буурчээ. Энэ оны жилийн эцсээр мөн буурах хандлага ажиглагдаж байна.



Дүрслэл 1. Гадаад худалдааны нийт эргэлт (он тус бүрийн эхний хагас жилд, сая ам.доллар)



Дүрслэл 2. Гадаад худалдааны тэнцэл (он тус бүрийн эхний хагас жилд, сая ам.доллар)



Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарахад Оюу Толгойн экспорт эхэлсэн, эдийн засаг огцом агшсанаас үүдэлтэй нийт импорт эрс багассан нь голлох нөлөө үзүүлэв.

**Улсын төсөв:** Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 2016 оны эхний хагас жилийн байдлаар 2,541.3 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3,665.1 тэрбум төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэл 1,123.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

**Төлбөрийн тэнцэл:** Төлбөрийн тэнцэл 2016 оны 2 дугаар улирлын байдлаар 8.2 сая ам.долларын алдагдалтай гарсан

байна. Урсгал данс 137.4 сая ам.долларын алдагдалтай, харин хөрөнгө санхүүгийн тэнцэл 249.9 сая ам.долларын ашигтай гарав.

**Төгрөг ба гадаад валют:** Гадаад валютын улсын нөөц 2016 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар буюу 389.0 сая ам.доллараар буурч 1,266.6 сая ам.долларт хүрлээ. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш өмнөх оны мөн үеэс 2014 онд 26.9 хувь, 2015 онд 4.3 хувиар тус тус суларч байсан. 2016 оны 6 дугаар сарын байдлаар 3.2 хувиар суларч, албан дундаж ханш 1,964.9 төгрөгт хүрсэн.

# БҮЛЭГ 3

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 3.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжиж буй болон хөгжингүй зах зээлтэй орнуудын санхүүгийн зах зээлд макро эдийн засаг болон мөнгө, сангийн бодлогын нөлөөлөх хувьсагч үзүүлэлтүүдийн талаарх судалгааг хийж, холбогдох бодлогын зөвлөмжүүдийг олон нийтэд тогтмол хүргэх ажлыг хийж гүйцэтгэдэг бөгөөд дээрх байгууллагуудаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны төвлөрөл, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн хэсгүүдэд хуваан авч үздэг.

#### 3.1.1. Зах зээлийн үнэлгээ


Эдийн засгийн өсөлтөд урт болон богино хугацаанд үзүүлэх нөлөөлөл, тус зах зээлийн багтаамжийг илэрхийлэгч үзүүлэлт нь зах зээлийн үнэлгээ юм. Энэхүү үзүүлэлтийн

өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг шууд илэрхийлэгч индикатор болдог.

2016 оны 2 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,423.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.6 тэрбум төгрөг буюу 1.03 хувиар өсчээ. Тайлант хугацаанд ТОП-20 индекст багтдаг "АПУ" ХК-ийн хувьцааны ханш 17.0, "Сүү" ХК-ийн үнэлгээ 39.0, "Монгол Шуудан" ХК-ийн үнэлгээ 62.0 хувиар тус тус өссөн бол ТОП-20 индексийн сагсанд багтдаг уул уурхайн салбарын компаниуд болох "Таван толгой" ХК, "Шивээ овоо" ХК, "Бэрх уул" ХК-уудын хувьцааны ханш 63.0, 52.0, 70.0 хувиар тус тус буурчээ.

Нийт зах зээлийн үнэлгээний 89.6 хувийг 30 компани бүрдүүлж байгаагаас уул уурхайн салбар дахь компаниудын үнэлгээ зах зээлийн үнэлгээний өсөлт, бууралтад шууд нөлөө үзүүлж байна.

Дүрслэл 3. Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 3. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани

№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/	№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/
1	АПУ	312.66	16	Талх чихэр	18.98
2	МИК холдинг	261.77	17	Дархан нэхий	18.24
3	Багануур	81.80	18	Бэрх уул	17.63
4	Таван толгой	75.31	19	Хай би ойл	16.89
5	Говь	63.97	20	Баянгол зочид буудал	16.08
6	Сүү	52.41	21	Материалимпекс	12.33
7	Шивээ овоо	38.58	22	Гермес центр	11.00
8	Шарын гол	38.37	23	Атар-өргөө	10.80
9	Би Ди Сек	31.11	24	Силикат	10.43
10	Монгол шуудан	28.88	25	Махимпекс	10.07
11	Гутал	26.71	26	Женко тур бюро	7.00
12	Монгол секюритиес	26.64	27	Ариг гал	6.96
13	Тахь-ко	22.61	28	Монгол шилтгээн	6.50
14	Монголын цахилгаан холбоо	20.44	29	Фронтинер лэнд групп	6.17
15	Улсын их дэлгүүр	19.11	30	Хөх ган	5.98

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Зах зээлийн үнэлгээний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин:**

Тайлант хугацааны ЗЗҮ-г үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ий хэмжээтэй харьцуулахад 22.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.6 хувиар буурчээ. Харин тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулан хөрвөх чадварыг тооцсон дүн 0.93 нэгж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.53 хувиар өссөн байна.


Хөрвөх чадварын түвшин өсөхөд “Монгол шуудан” ХК-ийн 33.8 сая ширхэг хувьцааг 6.26 тэрбум төгрөгөөр хувьцааны анхдагч зах зээлд арилжсан нь гол нөлөөг үзүүлсэн ба энэ нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 47.3 хувийг эзэлж байна.

**Шигтгээ 1:** Манай улсад хувьцааны хөрвөх чадварын түвшин бусад хөгжиж буй зах зээлтэй орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байгаа ба хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцаа хэт төвлөрсөн, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, хувьцааны үнэ ханш зах зээлийн үр ашгийн зарчмаар бус дотоод мэдээлэл эзэмшигчид болон зах зээлийг урвуулан ашиглах үйлдлээс үүдэлтэйгээр тогтох хандлагатай, хангалттай хэмжээний шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ байхгүй, олон нийтийн хөрөнгө оруулалт, хувьцааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг хүчин зүйлс гол нөлөөг үзүүлж байна.

Иймээс хөрвөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг богино, дунд хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Үнэт цаас зээлдүүлэх, маржин арилжааг хөгжүүлэх;
- Бүртгэлийн шаардлага хангаагүй компаниудын үнэт цаасыг биржийн бүртгэлээс хасах, хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх;
- Зах зээлийг идэвхжүүлэгч /market maker/-ийн үйл ажиллагааг сайжруулах;
- Үнэт цаасны барьцааны зохицуулалтыг боловсронгуй болгох, барьцааны тооцоолол, удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх;
- Хувьцаат компаниудын төвлөрлийг бууруулж, олон улсын жишигт нийцүүлэх;
- Хамтын хөрөнгө оруулалтын сангуудыг хөгжүүлэх;
- Төрийн өмчит ХК-уудыг биржээр дамжуулан хувьчлах ажлыг эрчимжүүлэх, бусад хувийн томоохон компаниудыг IPO хийж, олон нийтийн компани болоход эдийн засгийн хөшүүрэг болон бодлогоор дэмжлэг үзүүлэх.

Дүрслэл 4. Нэрлэсэн ДНБ-нд ЗЗҮ-ний эзлэх хувь




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

3.1.2. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Тайлант хугацааны ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.3 хувиар буурч, 12,274.16 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 12,685.91, доод үзүүлэлт 10,485.74, дундаж үзүүлэлт 12,274.16 нэгж байна.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.1 хувиар буурч, 870.9 нэгжид хүрчээ. Тус индексийн дээд үзүүлэлт 892.62 нэгж, доод үзүүлэлт 761.16 нэгж, дундаж үзүүлэлт 824.80 нэгжтэй гарлаа.

Дүрслэл 5. ТОП-20 индекс



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Шигтгээ 2:** Зах зээлийн үнэлгээ, ТОП-20 индексийн динамик үзүүлэлтээс харахад 2007, 2011 онуудад огцом өсөлт ажиглагдсан бөгөөд 2007-2008 оны хооронд нийт 8 компани үнэт цаасаа олон нийтэд санал болгон арилжаалсан нь арилжааны хэмжээ, зах зээлийн үнэлгээг огцом өсгөхөд нөлөө үзүүлжээ.

2011 онд зах зээлийн үнэлгээ огцом нэмэгдэн 2 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д харьцуулсан харьцаа 20.0 хувь болов. Энэ нь 2010-2011 онд дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ ханш огцом өсч, эрдэс баялгийн

салбарт гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом нэмэгдэн, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д арилжаалагдаж буй "Шарын гол" ХК, "Багануур" ХК, "Таван толгой" ХК, "Шивээ овоо" ХК-уудын хувьцааны үнэ ханш нэмэгдсэн. Түүнчлэн төрөөс иргэдэд үнэ төлбөргүйгээр "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 1,072 ширхэг хувьцааг тараахаар шийдвэрлэж, үнэт цаасны данс шинээр нээх, хуучин хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн дансаар дамжуулан хувьцааны зарах захиалга нэмэгдсэн зэрэг нь зах зээлийн үнэлгээг огцом нэмэгдүүлэх үндсэн шалтгаан тус тус болжээ.

2012 оноос хойших хугацаанд макро эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ ханш огцом унаснаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ зогссонтой холбоотойгоор биржид бүртгэлтэй уул уурхайн болон барилга, боловсруулах салбарын компаниудын хувьцааны ханш огцом унаж, зах зээлийн үнэлгээ тасралтгүй буурч ирлээ.

**Дүгнэлт:** Хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтөд үнэт цаасны зах зээлийн үзүүлэх нөлөөлөл өндөр, урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэрийг хангах үндсэн хэрэгсэл нь болж, эдийн засгийн мөчлөгийг сөрөх шинжийг агуулдаг бол хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн өсөлтөөс үнэт цаасны зах зээлийн хөгжил шууд хамаарах хандлагатай байдаг нь манай оронд ч ажиглагдаж байна. Цаашид төрийн зохицуулах байгууллагаас үнэт цаасны зах зээлийн дунд, урт хугацааны хөгжлийн бодлого, зохицуулалтыг мөчлөг сөрсөн хэлбэрээр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

Аливаа улсын эдийн засгийн өсөлт, санхүүгийн зах зээлийн хөгжил нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшин ямар байгаагаас шууд хамаардаг. Гэтэл манай улсын санхүүгийн зах зээл нь банк давамгайлсан санхүүгийн тогтолцоотой, хадгаламжийн хүүгийн түвшин хөгжиж буй болон хөгжингүй орнуудын дунджаас өндөр байгаа нь урт хугацаанд нийгэм, эдийн засагт үр ашгаа өгөх төслүүдийг үнэт цаасны зах зээлээр дамжуулан санхүүжүүлэх боломжийг хязгаарлаж, уг салбарыг хөгжүүлэх боломжийг бууруулж байна.

Үнэт цаасны зах зээлийн индексүүдийн хөдөлгөөн 2011 оноос буурах хандлага ажиглагдаж байгаа бөгөөд 2005

оноос 2016 оны 2 дугаар улирлын ТОП-20 индексийн тэгш хэмийн түвшинг эконометрикийн аргачлал ашиглан тооцвол skewness шинжүүр 0.09, стандарт хазайлт 6,932.60 нэгж байгаа нь үнэт цаасны ханш хэт өндөр савлагаатай, ханшийн мэдээлэлд тулгуурлан тухайн хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад эрсдэлтэй болохыг харуулж байна.

**Шигтгээ 3:** Үнэт цаасны зах зээлийн үр ашигт, тогтвортой байдал нь мэдээллийн үр ашгийн хэлбэрт оршдог тул үр ашигт зах зээлийн төсөөллийн (Efficient market hypothesis) загварын weak form efficiency хэлбэрийг ашиглан 2005-2015 оны үнэт цаасны индексийн үзүүлэлтэд шинжилгээ хийж, математик статистикийн аргаар хэмжихэд дараах дүгнэлт гарлаа.

Монгол Улсын үнэт цаасны зах зээл үр ашигтай зах зээлийн шинжийг агуулаагүй, өөрөөр хэлбэл үнэт цаасны зах зээл өнгөрсөн хугацааны индексийн өгөөж болон үнийн өөрчлөлтөд агуулагдаж буй мэдээллээс хамааралгүй, зах зээл дэх дотоод мэдээлэл эзэмшигч, мэргэжлийн оролцогч байгууллагын шууд оролцоо буюу үгсэн тохиролцох замаар зохиомлоор ханш тогтох, энэ нь эргээд үнэт цаасны индексэд нөлөөлөх эрсдэл өндөр буйг харуулсан.


Тиймээс үнэт цаасны арилжааны хяналтыг сайжруулах, дотоод мэдээлэл эзэмшин арилжаанд оролцох, ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах үйлдлийг таслан зогсоох хатуу зохицуулалтын орчин /enforcement/-г бүрдүүлэх шаардлагатай.

энэ оны эхний хагас жилийн байдлаар 1 компанийн олон нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг бүртгээд байна.

### 3.2. ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 300 компани бүртгэлтэй байгаа бөгөөд

Дүрслэл 6. Хувьцаат компанийн тоо



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ 2016 - II УЛИРАЛ

Хорооны 2016 оны 20 дугаар тогтоолоор “Ай Түүлс” ХХК-ийн нийт 4,324,263 ширхэг хувьцааг бүртгэсэн бөгөөд үүнээс 2,431,548 ширхэгийг тус компанийн үүсгэн

байгуулагчид, үлдэх 1,892,715 ширхэгийг олон нийтэд санал болгон арилжаалахаар үнэт цаасны танилцуулгад дурдсан байна.

### Хүснэгт 4. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	СЗХ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	“ҮЦТХТ” ХХК
Төрийн өмчит	32	21	22
Төрийн өмчийн оролцоотой	10	16	15
Орон нутгийн оролцоотой	15	-	8
Хувийн өмчит	243	199	276
<b>Нийт</b>	<b>300</b>	<b>236</b>	<b>321</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2013-2016 оны хооронд Хорооноос хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, Хорооны бүртгэлийг бүртгэлийн /listing/ хэлбэрээс зөвшөөрлийн /registering/ хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар

хүлээсэн үүргээ сүүлийн 3-аас дээш жилийн хугацаанд тогтмол биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, хууль хяналтын байгууллагуудад шилжүүлэх хийгээд компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

### Хүснэгт 5. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц (ширхэг)

Үнэт цаас гаргагчийн ангилал	2014 он	2015 он	2016-II
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,913,776	2,809,930	2,818,124
Төрийн мэдлийн хувьцаа	2,254,152	2,246,316	4,174,753
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
<b>Нийт</b>	<b>5,196,974</b>	<b>5,085,292</b>	<b>7,021,922</b>
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	967,134	2,558,176	2,558,176
Эрдэнэс Тавантолгой /ААН/	4,915	5,139	5,130
Эрдэнэс Тавантолгой /Төр/	14,027,951	12,436,685	12,436,694
<b>Нийт</b>	<b>15,000,000</b>	<b>15,000,000</b>	<b>15,000,000</b>
Хаалттай ХК	-	172,753	174,958
<b>Нийт</b>	<b>-</b>	<b>172,753</b>	<b>174,958</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 15 ордын тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа хуулийн этгээдүүдийн хувьцааны 10 хувийг хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх нь үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Өнөөдрийн байдлаар дээрх ордын тусгай зөвшөөрөл

эзэмшиж байгаа нийт 24 хуулийн этгээд байгаагаас 4 /“Багануур” ХК, “Шивээ овоо” ХК, “Таван толгой” ХК, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК/ нь хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт: Тайлант хугацаанд “ҮЦТХТ” ХХК нийт 6 ХК-тай ногдол ашгийн гэрээ байгуулж 16,516 харилцагчийн дансанд 5.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг байршуулаад байна.

**Хүснэгт 6. Ногдол ашиг тараасан хувьцаат компани**

№	ХК-ийн нэр	Нийт ҮЦ-ны тоо ширхэг	Нэгж хувьцаанд тараасан	ХЭ-ийн тоо	ҮЦ-ны тоо /ширхэг/	Мөнгөн дүн
1	Адуунчулуун	3,151,304	90.00	1,176	392,534	35,328,060.00
2	Тахь-Ко	1,189,983	97.20	624	1,189,983	115,666,347.60
3	МИК холдинг	20,709,320	217.08	104	20,709,320	4,505,739,518.52
4	Атар-Өргөө	174,136	270.00	351	13,848	3,738,960.00
5	АПУ	74,287,700	63.00	3,075	5,360,899	337,736,637.00
6	Могойн гол	829,622	4.50	952	406,515	1,829,317.50
<b>Нийт</b>				<b>6,282</b>	<b>28,073,099</b>	<b>5,000,038,840.62</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид:**

Тайлант хугацаанд 61 ҮЦК Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас арилжаа эрхлэх 2, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 12 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 37 хуулийн этгээд байна.

**Хүснэгт 7. Зохицуулалттай этгээдийн тоо**

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын үйлчилгээ үзүүлэх	0
5	Хөрөнгө оруулалтын менежментийн	12
6	Брокер, дилер	62
7	Кастодиан банк	3
8	Андеррайтер /давхардсан тоогоор/	26
9	Хөрөнгө оруулалтын зөвлөх / давхардсан тоогоор/	15
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
11	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	37
12	Аудитын компани	44
13	Үнэлгээний компани	20
14	Хуулийн компани	20

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 компанид олгосон бол Засгийн газрын 2015 оны 147-р тогтоол, Сангийн сайдын 2015 оны 280 дугаар тушаалын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс “ҮЦТТХТ” ХХК-ийг үнэт цаасны төлбөр тооцоо болон төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий бие даасан 2 хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулах чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллав.

Хорооноос 2015 оны 312 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны бирж” ХХК-д үнэт цаасны арилжаа, тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд ингэснээр үнэт цаасны зах зээлд 2 дахь бирж байгуулагдан үйл ажиллагаа явуулах боломж бүрдээд байна. Үнэт цаасны зах зээлд арилжаа эрхлэх байгууллагууд төрөн гарах нь зах зээл дээрх төгс шударга өрсөлдөөн бий болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үйлчилгээний өртөг /transaction cost/-ийг бууруулах, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд хямд зардлаар санхүүжилт татах боломж бүрдээд байна.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн 58 брокер, дилерийн компаниас 42 компани арилжаанд оролцож, оны эхнээс өссөн дүнгээр нийт 66.6 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ.

Хүснэгт 8. Арилжаанд эзлэх хувь

№	Компанийн нэр	Арилжааны хэмжээ	Хувь
1	Тэнгэр капитал	19,212,369,456.30	28.9%
2	Ард секьюритиз	11,214,557,024.00	16.8%
3	Би Ди Сек	9,752,869,568.73	14.6%
4	Гаули	9,256,333,761.37	13.9%
5	Новел инвестмент	5,407,602,398.36	8.1%
6	Стандарт инвестмент	2,210,412,380.70	3.3%
7	Дэу секьюритиз монгол	1,764,729,548.90	2.7%
8	Голомт секьюритиз	1,450,321,640.67	2.2%
9	Бусад 34 брокер, дилерийн компани	6,319,486,562.45	9.5%
	<b>Нийт</b>	<b>66,588,682,341.48</b>	<b>100%</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Брокер, дилерийн компаниуд үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцохгүй байгаад дараах хүчин зүйлс нөлөө үзүүлж байна. Үүнд:

- Эдийн засгийн өсөлт саарсантай холбоотойгоор томоохон уул уурхайн хувьцаат компаниудын хувьцааны үнэ ханш унаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох идэвх буурсан;
- Брокер, дилерийн компаниудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавх сул, дотоод хяналт, эрсдэлийн оновчтой тогтолцоо бүрдээгүй, санхүүгийн бусад этгээдүүдтэй харьцуулахад зах зээлд эзлэх хувь хэмжээ бага;
- Биржийн арилжаанд үнэт цаас зээлээр худалдах, худалдан авах ажиллагаа болон итгэмжлэгдсэн дилер /market maker/-ийн үйлчилгээ бүрэн нэвтрээгүй;
- Олон нийтийн санхүүгийн боловсрол сулаас үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийхээс илүүтэйгээр банкны хадгаламжид хөрөнгөө байршуулах сонирхол өндөр;
- Үнэт цаасны төлбөр тооцооны нэгдсэн тогтолцоо бүрдээгүйгээс брокер, дилерийн компани дан ганц нэг төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дагнан төрөлжиж хөдөө аж ахуйн түүхий эд, үүсмэл үнэт цаасны арилжаанд оролцох боломжгүй байгаа нь тус тус нөлөөлж байна.

Хорооны тайлан тэнцлийн цахим системд энэ оны 2 дугаар улиралд тайлангаа ирүүлсэн 54 брокер, дилерийн компаниудын нэгтгэлийг хураангуй байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 9. Нийт хөрөнгө (төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлант үе
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	48,586,452,376.97
2	Эргэлтийн бус хөрөнгө	26,585,288,293.23
3	Нийт актив	75,171,740,670.20
4	Өр төлбөр	12,056,696,668.58
5	Эздийн өмч	63,115,044,001.63
6	Нийт пассив	75,171,740,670.20

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын нэгтгэлд хамрагдсан ҮЦК-уудын нийт хөрөнгө тайлант үеийн байдлаар 75.2 тэрбум төгрөг байгаагаас 64.6 хувийг эргэлтийн хөрөнгө, 35.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлжээ. Нийт эх үүсвэрийн 16.0 хувийг өр төлбөр, 84.0 хувийг эздийн өмч бүрдүүлсэн. Үүнээс богино хугацаат өр төлбөр 15.5 хувийг, урт хугацаат өр төлбөр 0.6 хувийг, урт хугацаат зээл 1.6 хувийг тус тус эзэлж байна.

Эздийн өмчийн хувьд нийт эх үүсвэрийн 84.0 хувийг бүрдүүлж байгаа ба үүнээс нэмж төлөгдсөн капитал 10.7 хувийг, сангууд 0.03 хувийг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 4.96 хувийг, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц -0.05 хувийг, эздийн өмчийн бусад хэсэг 4.1 хувийг, хуримтлагдсан алдагдал -0.21 хувьтай байна.



### Хүснэгт 10. Нийт орлого (төгрөгөөр)

№	Орлогын хураангуй тайлан	Тайлант үе
1	Үйл ажиллагааны орлого	2,487,854,560.74
2	Ногдол ашгийн орлого	439,654,298.02
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	3,309,261,967.50
4	Ажилтнуудын цалингийн зардал	1,539,720,825.83
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	274,360,172.61
6	Санхүүгийн зардал	246,402,145.37
7	Бусад зардал	20,620,133.76
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-47,254,727.03
9	Бусад ашиг (алдагдал)	-1,253,500,683.69
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,177,761,479.39
11	Орлогын татварын зардал	80,561,779.72
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,258,323,259.11

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын нэгтгэлд хамрагдсан нийт 54 ҮЦК-уудаас тайлант хугацаанд 37 үнэт цаасны компани алдагдалтай ажилласан бол 16 ҮЦК үнэт цаасны арилжаанд оролцож, шимтгэлийн орлого олоогүй тул түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдал хүлээжээ. Компаниудын үндсэн үйл ажиллагааны зардлууд болох цалин, төлбөр, хураамж, санхүүгийн болон түрээсийн зардлууд өндөр хувьтай байгаа нь ашиг буурахад голлох нөлөөг үзүүлж байна.

**Шигтгээ 4:** Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сангаас Монгол Улсын эдийн засгийн нөхцөл, байдалд хийсэн судалгаа, тайлангаас харахад 2016 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 1-ээс доош хувьтай гарна гэж таамагласан байна. Тухайлбал, Дэлхийн банк Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 0.8 хувь, Олон Улсын Валютын Сан 0.4 хувь, Азийн Хөгжлийн банк 0.1 хувиар тус тус өснө гэж таамагласан бол Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн өсөлтийг 2016 оны эцэст 1.3 хувьтай гарна гэсэн хүлээлттэй байна.

Мөн эдийн засгийн өсөлт удааширсантай холбоотойгоор үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалттай этгээдүүд ашиггүй ажиллаж, арилжаанд оролцохгүй, үйл ажиллагаа явуулахгүй байдал нэмэгдэн, тэдгээрийн үйл ажиллагааны алдагдлын хэмжээ өсөх төлөв ирэх жилүүдэд ч үргэлжлэх хандлага ажиглагдаж байна.

Цаашид Хороо ҮЦК-уудаас татан төвлөрүүлэх, шимтгэлийн хэмжээг бууруулах, хөнгөлөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс гадна үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэхэд шалгалт хийж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх, санхүүгийн тайлагнал,

мэдээллийн ил тод байдлыг хангуулах, ҮЦК-уудыг нэгдэж нийлэхийг бодлогоор дэмжих, төлбөрийн чадваргүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд ҮЦК-уудыг хөрөнгөжүүлэх, нэгтгэх, нийлүүлэх бодлого баримтлах шаардлагатай.

### 3.3. ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан нийт 98.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66 хувиар буурчээ. Нийт арилжааны 13.4 хувийг хувьцаа, 81.3 хувийг засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны анхдагч зах зээлийн арилжаа, 5.3 хувийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлсэн байна.

Дүрслэл 7. Нийт үнэт цаасны арилжааны бүтэц (хувиар)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аар арилжаалсан үнэт цаасны тоо ширхэг өмнөх оны мөн үеэс 1.5 дахин өссөн нь төрийн өмчит “Монгол шуудан” ХК хувьцааны 66 хувийг олон нийтэд арилжаалсантай холбоотой.

Хүснэгт 11. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт


Арилжааны үзүүлэлтүүд	2015 оны 2-р улирал	2016 оны 2-р улирал
Үнэт цаасны тоо ширхэг /сая ширхэг/	19.3	47.9
Нийт үнийн дүн /тэрбум төгрөг/	290.5	98.6

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.3.1. Хувьцааны арилжаа

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 123 удаагийн арилжаагаар 109 компанийн 47.0 сая ширхэг хувьцааг 13.2 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Хувьцааны арилжааны 47.3 хувь буюу 6.3 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 21.3 хувь буюу 2.8 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 30.8 хувь буюу 4.2 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 0.06 хувь буюу 8.4 сая төгрөгийн гүйлгээг тендер саналын арилжаа тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 8. Хувьцааны арилжаа




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд багцын арилжаагаар “Мон-Ит Булигаар” ХК, “Монгол шуудан” ХК, “АПУ” ХК, “Хөсөг трейд” ХК, “Шимтлэг” ХК-уудын нийт 8.1 сая ширхэг хувьцааг 2.8 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны

үнийн дүнгийн 21.3 хувийг эзэлсэн бол тендер саналын арилжаагаар “Түшиг Уул” ХК-ийн 17.0 мянган ширхэг хувьцаа арилжигдсан байна.

Дүрслэл 9. Шинээр болон нэмж үнэт цаас гаргагчдын тоо



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн журамд зохицуулалтын өөрчлөлт

хийж, Хороо болон хөрөнгийн биржийн чиг үүргийн давхардлыг бууруулах, компаниуд хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх, урт хугацааны санхүүжилт татах орчныг улам хялбаршуулаад байна.

Хүснэгт 12. Шинээр болон нэмж үнэт цаас гаргагчдын мэдээлэл (төгрөгөөр)

№	Огноо	Үнэт цаас гаргагч	Нэгж хувьцааны үнэ	Нийт тоо ширхэг	Бүртгэлтэй үнэт цаасны тоо ширхэг	Нэмж гаргасан хувьцааны нийт үнэлгээ	Нийт хувьцааны үнэлгээ
1	2016.01.29	"Ай Түүлс" ХХК	1,000.00	1,892,715	4,324,263	1,892,715,000	4,324,263,000
2	2016.06.15	"Багануур" ХК	100.00	9,870,287	30,844,647	26,156,260,550	70,973,532,747

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.3.2. Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

"Монголын хөрөнгийн бирж" ХК тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааг 16 удаа явуулж, 12, 28, 39, 52 долоо хоногийн хугацаатай нийт 853.0 мянган

ширхэг үнэт цаасыг 80.1 тэрбум төгрөгөөр арилжсан бол хоёрдогч зах зээлийн арилжаагаар 53.2 мянган ширхэг үнэт цаасыг 5.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Дүрслэл 10. ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2012 оноос эхлэн Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг бүхэлд нь Монголбанкны арилжааны платформуор явуулж байсан бөгөөд 2014 оны 11 дүгээр сараас ЗГҮЦ-ны жижиглэнгийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар хийж эхэлсэн.

Тайлант хугацаанд "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар дамжуулан арилжаалагдсан ЗГҮЦ-ны хэмжээ буурсан нь биржийн нийт үнэт цаасны арилжааны үнийн дүн буурахад голлох нөлөө үзүүлжээ. Мөн макро эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал муудсантай холбоотойгоор Засгийн газрын зүгээс төсвийн алдагдлыг үнэт цаас гарган нөхөх бодлогын арга хэмжээг өөрчилсөн, мөн дотоодын зах зээлээс үнэт цаас гарган санхүүжилт татахад хүндрэлтэй байгаа нь ЗГҮЦ-ны нийлүүлэлт буурахад тус тус нөлөөлсөн байна.

**Шигтгээ 5:** Монголбанкаар арилжаалагдаж буй ЗГҮЦ-ыг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах ажиллагааг үе шаттайгаар нэмэгдүүлэх, уртасгах чиглэлээр Хороо, Сангийн яамтай хамтран ажиллах шаардлагатай ба цаашид хоёр талд арилжаалж буй үнэт цаасны арилжааг хөрөнгийн бирж рүү бүрэн шилжүүлснээр дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид ЗГ-ын бондын зах зээлд шууд оролцож, хүүгийн өндөр өгөөж хүртэх боломж бүрдэнэ.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/ 2014, 2015 оны олон улсын үнэт цаасны зах зээлийн эрсдэлийн талаарх тойм тайлан, зөвлөмжүүдээрээ хөгжиж буй орнуудад засгийн газрын болон компанийн өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхжүүлэх чиглэлээр томоохон санал, дүгнэлтүүдийг гишүүн орнууддаа өгсөн бөгөөд цаашид ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааг идэвхжүүлэхээс илүүтэйгээр хоёрдогч зах зээлийн арилжааг хөгжүүлэх, арилжааны хэмжээ, өгөөжийн муруйд тулгуурлан санхүүгийн зах зээлд жишиг хүүгийн түвшинг тогтоох шаардлагатайг онцолсон билээ.

Олон улсын санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид нь хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлэхэд CAPM, APT загваруудыг түлхүү ашигладаг бөгөөд эдгээр загварыг ашиглан өгөөж, эрсдэлээ тооцоход зайлшгүй жишиг хүүгийн түвшинг үндэсний хэмжээнд бий болгох шаардлага тулгардаг. Тиймээс гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, эрсдэл, өгөөжийг тооцоход зайлшгүй Монголбанк, Сангийн яамтай хамтран ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, өгөөжийн муруйгаас хамаарсан жишиг хүүгийн түвшинг тогтоох нь зүйтэй юм.

### 3.3.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Хорооны 2016 оны 97 дугаар тогтоолоор “МИК Актив Ес” ХХК-ийн 1,375,483 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /ХБҮЦ/-ыг бүртгээд байна. Энэ оны 2 дугаар

улирлын өссөн дүнгээр 9 удаагийн үнэт цаасжуулалт хийгдсэнээс нийт 220.8 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгдсөн байна.

Хүснэгт 13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (тэрбум төгрөг)

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	“ҮЦТХТ” ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо	2016.6.30-ний үлдэгдэл
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658	328.1
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290	224.8
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593	328.5
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510	459.4
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805	301.2
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188	267.8
“МИК актив долоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414	299.6
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291	189.8
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719	137.5
<b>Нийт</b>	<b>2,536.7</b>	<b>2,495</b>	<b>49,468</b>	<b>2,536.7</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

“МИК ОССК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах хүрээнд тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, Хорооноос ХБҮЦ гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зөвшөөрөл авсан бөгөөд 2015 онд “МИК ОССК” ХХК нь олон нийтэд 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,709,320 ширхэг үнэт цаасыг санал болгож, нээлттэй хувьцаат компани болсон. ХБҮЦ-ны 90 хувийг Монголбанк, үлдсэн 10 хувийг ипотекийн зээлийн багц хөрөнгөө худалдсан банкнууд эзэмшиж байна.

### 3.3.4. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаа

Тайлант хугацаанд “ХААБ” ХХК-аар дамжуулан нийт 303.5 тэрбум төгрөгийн бараа, түүхий эд арилжаалагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.4 тэрбум төгрөг буюу 1.8 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ. Нийт арилжааг бүтцээр нь ангилан үзвэл ноолуур 295.0 тэрбум төгрөг, хонины ноос 6.1 тэрбум төгрөг, тэмээний ноос 1.8 тэрбум төгрөг, ямааны завод ноос 0.6 тэрбум төгрөг, бодын хөөврийг 0.03 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

Хүснэгт 14. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ

№	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/
1	Ноолуур	507,162	295.00
2	Хонины ноос	38,474	6.10
3	Тэмээний ноос	1,822	1.75
4	Ямааны завод ноос	104,409	0.60
5	Завод ноос	11	0.00
6	Бодын хөөвөр	16	0.03
	<b>Нийт</b>	<b>651,894</b>	<b>303.49</b>

Эх үүсвэр: Хөдөө аж ахуйн бирж

### 3.4. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ


“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 865,440 данс, 136,060 холболтын данс нээгдсэн.

Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 860,871 дотоодын иргэн, 1,887 гадаадын иргэн, 2,505 дотоодын аж ахуйн нэгж, 177 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 45,365 данс шинээр нээгдсэнээс 45,335 нь дотоодын иргэн, 21 нь гадаадын иргэн, 9 нь дотоодын аж ахуйн нэгжийн данс байна.

Тайлант хугацаанд Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв /ҮЦТХТ/-д шинээр нээгдсэн дансны тоо 50,405 болтол огцом нэмэгдсэн нь Засгийн газраас “Сайн хувьцаа” хөтөлбөр хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг худалдах захиалга өгөн, шинээр данс нээх болсон нь нөлөөлсөн.

Арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалын нийт 115 гүйлгээгээр давхардсан тоогоор 52 ХК-ийн 40,541 ширхэг хувьцаа, бэлэглэлээр 5 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 7 ХК-ийн 141,350 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлжээ.

Дүрслэл 11. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 3.22 хувьтай байгаа бол дотоодын

аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 96.8 хувьтай байна.

Дүрслэл 12. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Шигтгээ 6:** Үнэт цаасны зах зээлд дээрх гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох хувь хэмжээ 2012 оноос тасралтгүй буурч хандлага ажиглагдаж байгаа бөгөөд үүнд дараах хүчин зүйлс нөлөө үзүүлж байна.

- Макро эдийн засгийн өсөлт саарч, уул уурхайн түүхий эдийн үнэ ханш дэлхийн зах зээлд унасантай холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулагчдын уул уурхайн хувьцаат компанийн хувьцааг худалдан авах сонирхол буурсан, зах зээлд хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл дутмаг, хөрвөх чадварын түвшин доогуур, гадаад валютын эрсдэлээс хамгаалах механизм бүрдээгүй;
- Салбарын түвшинд гадаадын иргэн, аж ахуй нэгжийн өмчлөх эрхийг баталгаажуулагч кастодиан банкны үйлчилгээ зах зээлд хараахан нэвтрээгүй, гадаадын иргэдтэй холбоотой үнэт цаасны данс нээх ажиллагаа чирэгдэлтэй.

### 3.5. ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн төлөвийг голчлон үнэт цаасны мөнгөн гүйлгээ, төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүдээр авч үздэг.

#### 3.5.1. Үнэт цаасны арилжааны мөнгөн гүйлгээ

Тайлант хугацаанд төвлөрсөн хадгаламжийн дансаар нийт 633 харилцагчийн дансанд 1,420 удаа 507.2 тэрбум төгрөгийн орлогын гүйлгээ, 962 харилцагчийн 1,534 удаа 507.3 тэрбум төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ тус тус хийгдсэн бөгөөд гүйлгээний нийт дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 15. Мөнгөн гүйлгээний задаргаа (сая төгрөг)

Он	Орлого		Зарлага		Нийт	
	Гүйлгээний тоо	Үнийн дүн	Гүйлгээний тоо	Үнийн дүн	Гүйлгээний тоо	Үнийн дүн
2011-II	4,345	107,652.1	6,447	100,342.9	10,792	207,995.0
2012-II	5,165	120,685.7	7,025	102,235.6	12,190	222,921.3
2013-II	920	607,984.0	2,667	625,512.8	3,587	1,233,496.8
2014-II	1,059	713,596.3	1,833	720,656.7	2,892	1,434,253.0
2015-II	1,666	1,437,413.7	2,638	1,436,941.3	4,304	2,874,355.0
2016-II	1,420	507,160.6	1,534	507,303.1	2,954	1,014,463.7

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдсэн арилжааны мөнгөн төлбөрийн тооцоог арилжааны 4 банкаар дамжуулан хийсэн байна. Банк хооронд нийт 9.2 тэрбум төгрөгийн тооцоо гүйцэтгэснээс Голомт банкаар 3.1 тэрбум төгрөг, ХХБ-аар 1.7 тэрбум төгрөг, Хас банкаар 4.3 тэрбум төгрөг, ХААН банкаар 63.2 сая төгрөгийн гүйлгээ тус тус хийжээ.

### 3.5.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 317 ХК-ийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 20.2 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас гадна 22 төрлийн 23.0 сая ширхэг компанийн бонд, 110 төрлийн 3.8 сая ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна. Үүнээс 18 төрлийн 22.8 сая ширхэг компанийн бонд, 57 төрлийн 2.13 сая ширхэг Засгийн газрын бонд биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Мөн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай ХК-ийн 150.0 сая ширхэг хувьцаа, “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийн 22.7 сая ширхэг хувьцаа, «Апи ресурс» хаалттай ХК-ийн 2.2 сая ширхэг хувьцаа төвлөрсөн хадгаламжид тус тус бүртгэлтэй байна. Нийт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй 314 ХК /хаалттай 3 ХК-ийг хасч тооцов/-ийн 22.0 тэрбум ширхэг үнэт цаасны 69.3 хувийг төрийн өмчийн оролцоотой компанийн, 0.13 хувийг орон нутгийн оролцоотой компанийн, 30.6 хувийг төрийн мэдлийн бус буюу хувийн компанийн хувьцаа тус тус бүрдүүлж байна.

Хувьцаат компанийн 5-аас дээш хувийг эзэмшдэг 1,038 хувьцаа эзэмшигчдэд 6.7 тэрбум ширхэг хувьцаа төвлөрсөн байна. Энэ нь нийт бүртгэлтэй хувьцааны 30.6 хувийг эзэлж байна.

Өнөөгийн үнэт цаасны зах зээлийн дэд бүтцэд дундын зуучлалын /ССР/ тогтолцоо үүсэн бий болох шатандаа байгаа, мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавх сул байгаагаас зах зээлд үнэт цаас зээлээр худалдах, худалдан авах, барьцааны удирдлага, үүсмэл хэрэгсэл бий болоход бэрхшээл тулгараад байна.

**Дүгнэлт:** Цаашид, нэгэнт зах зээлд үүсэн бий болсон 3 биржийн төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг уялдуулах, тооцооны үйл ажиллагааг нэгдсэн тооцооны төвөөр гүйцэтгүүлэх, биржүүдийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагчдад олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дороос өртөг багатайгаар хүргэх ажлуудыг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх чиглэлээр Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, биржүүд хамтран ажиллах нь зүйтэй.

## 3.6. ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ

### 3.6.1. Төрийн зохицуулалт, хяналтын орчин

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн тогтолцоо нь банк давамгайлсан бүтэцтэй буюу нийт санхүүгийн салбарын 95.7 хувийг дангаар банкны салбар бүрдүүлж байгаа нь бусад санхүүгийн салбар /үнэт цаас, даатгал, бичил санхүү/-уудын хөгжлийг хязгаарлаж, бодит эдийн засагт гүйцэтгэх үүргийг бууруулж байна.

Үнэт цаасны зах зээл нь банкны салбарын богино хугацаат, өртөг өндөр санхүүжилтийн зуучлалын тогтолцоотой харьцуулахад нийгэм, эдийн засагт үр ашгаа өгөх урт хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг хямд өртгөөр санхүүжүүлэх бололцоог аж ахуйн нэгжүүдэд олгосноор дунд болон богино хугацаанд тухайн улсын эдийн засгийн өсөлт, санхүүгийн салбарын хөгжилд түлхэц үзүүлдэг. Хөгжингүй эдийн засагтай орнуудад эдийн засгийн өсөлт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үе шатнаас шууд хамаарч байгаа ба ДНБ-д эзлэх үнэт цаасны зах зээлийн үнэлгээ нь 100-аас дээш хувийг эзэлж байна.

Манай улсын үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын мэргэжлийн байгууллагуудын тоо банктай харьцуулахад өндөр хэдий ч эргэлтийн болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ бага, мэргэжлийн боловсон хүчний чадавхи сул, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хязгаарлагдмал байгаа нь тэдгээрийн үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж, эдийн засгийн хувьд ашиггүй ажиллах нөхцөлийг нэмэгдүүлж байна. Банкнаас бусад санхүүгийн салбаруудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэн тэнцвэртэй, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бий болгох шаардлага тулгарч байна.

Хөгжингүй болон хөгжиж буй зах зээлтэй орнуудад санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуурт тогтолцоонд шилжүүлэх зорилтын хүрээнд банкны салбарын оролцоог хязгаарлахын оронд үнэт цаас, даатгал зэрэг эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөртэй салбаруудад банкнуудыг үйл ажиллагаа явуулахыг дэмжих бодлого хэрэгжүүлж ирсэн нь санхүүгийн зах зээлийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэхэд чухал алхам болсон байдаг. Энэ туршлагын дагуу цаашид төрийн зохицуулагч байгууллагаас банкнуудыг “Хөрөнгө оруулалтын банк” хэлбэрээр үнэт цаас, даатгалын салбаруудад үйл ажиллагаа явуулахыг дэмжих замаар банк давамгайлсан бүтцээс гарах бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Манай улсын санхүүгийн зах зээлийн хяналт нь байгууллагын буюу салбарт суурилсан /Institutional approach/ бүтэцтэй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу тус Хороо нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банкнаас бусад санхүүгийн салбарт үйл ажиллагаа

явуулах мэргэжлийн оролцогч, зохицуулалттай этгээдэд тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулагдсан. Харин Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасны дагуу банкны

салбарын хяналтыг Монголбанк хэрэгжүүлж байна. Олон улс дахь санхүүгийн зах зээл дэх хяналтын бүтцийн хэлбэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 16. Санхүүгийн зах зээлийн хяналтын бүтэц

Аргачлал	Зохицуулалт	Улс
Institutional Approach	Төрийн зохицуулагч байгууллага нь хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн салбар эсхүл байгууллагад тавих хяналтыг хэрэгжүүлдэг /брокер, дилер, андеррайтер, банк г.м/	Хятад, Хонг Конг, Мексик, Монгол
Functional Approach	Тухайн бизнесийн байгууллагын төрлөөс нь хамаараад зохицуулагч байгууллага нь хяналтыг хэрэгжүүлэх ба олон зохицуулагч байгууллагатай байж болно. /Мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу ямар хэлбэртэй, аль салбарт хамаарах нь нөлөөлдөггүй байна/	Бразил, Франц, Итали, Испани
Integrated Approach	Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах бүх зохицуулалттай этгээдэд нэг л төрийн зохицуулагч байгууллага хяналт тавина.	Канад, Герман, Япон, Сингапур, Швейцарь, Англи, Солонгос
Twin Peaks Approach	Уг хандлага нь зохицуулалтын чиг үүргээсээ хамаараад зохицуулалт, хяналт тавих зохицуулах үүрэг нь хоёр зохицуулагч байгууллагад хуваагддаг төрөл бөгөөд нэг зохицуулагч нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах бол нөгөө зохицуулагч нь бизнесийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх, бизнесийн ёс зүйг үйл ажиллагаандаа хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьдаг байна.	АНУ

Эх үүсвэр: G30, Report of financial supervision structure

Сүүлийн жилүүдэд Банкны тухай хуулийн 6.2-т заасны дагуу кастодиан, андеррайтер, даатгалын зуучлагч, харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг банкнууд өөрийн охин, хараат компаниудаар гүйцэтгүүлэн, тэдгээрийн үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулах оролцоо нэмэгдэж байгаа нь санхүүгийн зах зээлд тавих хяналтыг сайжруулах, үр дүнтэй бодлогоор хянах төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагууд үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоогоо сайжруулах шаардлага үүсч байна.

Санхүүгийн зах зээлийн хөгжил өндөр түвшинд хүрсэн Азийн орнуудаас Япон, Солонгос, Сингапур зэрэг орнууд санхүүгийн хяналтын нэгдсэн тогтолцоотой байна. Ингэж төрийн нэг зохицуулагч байгууллага санхүүгийн салбарт тавих хяналтыг хэрэгжүүлснээр зохицуулалтын хүрээг зөв тодорхойлж, хяналт, шалгалтын үр дүнтэй бодлого боловсруулан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, сахин мөрдүүлэх оновчтой тогтолцоо бий болдог.

Мөн тухайн зохицуулагч байгууллага нэгдсэн хяналтыг хэрэгжүүлснээр үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, хяналтын бодлогоор дамжуулан хөгжүүлэх боломжтой болдог ба үр дүн нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд өсөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэх зэргээр илэрдэг байна.

Цаашид Хороо үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийн хяналтыг сайжруулах, салбарын хэмжээнд учрах эрсдэлийг бууруулах зорилтын хүрээнд эрсдэлд суурилсан хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, санхүүгийн нэгдсэн хяналтын тогтолцоо /Integrated approach/-нд шилжих бодлогын чиглэлийг баримтлах шаардлагатай.

### 3.6.2. Үнэт цаасны зах зээлийн бодлого, зохицуулалт


Төрийн зохицуулалтын бодлого нь үнэт цаас гаргагч, мэргэжлийн зуучлагчдын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийн зах зээлд хандах хандлагад нөлөөлөх замаар буюу зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг удирдах зохицуулалтын арга хэрэгслийг ашигладаг.

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд нэмэгдсэнээр нийт санхүүгийн зах зээлд эзлэх зуучлалын хувь хэмжээ өсөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэх, орлогын дахин хуваарилалтаар дамжин эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлэх боломж бүрддэг.

Тухайн төрийн зохицуулагч байгууллага үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хяналт тавихад зохицуулалт /regulation/, хяналт, шалгалт /supervision/, хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх /enforcement/ гэсэн гурван үндсэн хэрэгслийг хэрхэн оновчтойгоор хооронд нь уялдуулан хэрэгжүүлэхээс үнэт цаасны зах зээлийн хөгжлийн гарцын үзүүлэлт, цаашдын хөгжлийн түвшин шууд шалтгаалдаг байна.



Дүрслэл 13. Үнэт цаасны зохицуулалтын бодлого (IOSCO)



Хууль эрх зүйн орчин, хяналт шалгалт, хууль тогтоомжийг мөрдүүлэх гэсэн үндсэн 3 арга хэрэгслээс тэргүүлэх ач холбогдолтой нь хяналт, шалгалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх юм. Цаашид үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас хөгжиж буй орнуудын зохицуулагч байгууллагуудад хандан гаргасан зөвлөмж, зааврын хүрээнд мэргэжлийн зуучлагч, хөрөнгө оруулалтын сан, сангийн удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоонд шилжүүлэх, арилжааны хяналт, хувьцаат компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдалд тавих хяналт, шалгалтыг Өөрийгөө зохицуулах байгууллагад /ӨЗБ/-д шилжүүлэх нь зүйтэй.

Хороонд үнэт цаасны зах зээлд оролцогчдод мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрх хэмжээ хууль тогтоомжоор олгогдоогүй бөгөөд бусад хөгжсөн зах зээлтэй Япон, АНУ, БНСУ зэрэг орнуудын зохицуулагч байгууллага нь дээрх чиг үүргийг давхар хэрэгжүүлэх эрхтэй байдаг нь үнэт цаасны зах зээлийн хяналт, шалгалтын оновчтой тогтолцоо бүрдэх боломжтой болдог.

Манай орны хувьд дээрх хяналтын чиг үүрэг бүрэн нэвтрээгүй нь төрийн зохицуулагч байгууллагын хүний нөөцийн чадавх сул, хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх бие даасан мэргэшсэн нэгж бий болоогүй, эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн шалгах чиг үүргийг хүчний байгууллага дагнан хэрэгжүүлдэг, хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаа удаашралтай, хууль, хяналтын байгууллагын үнэт цаасны зах зээлийн хэрэг, маргааны талаарх мэдлэг хомс, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоо бүрэн нэвтрээгүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж байна.

Цаашид үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжиж, олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дараах хууль, эрх зүйн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр боловсруулах;
- Санхүүгийн зах зээлийн нэгдсэн хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэх;
- Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Өөрийгөө зохицуулах байгууллагуудыг чадавхжуулж, төрийн хяналт, зохицуулалтын зарим чиг үүргийг үе шаттайгаар шилжүүлэх.

### 3.6.3. Хяналт шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас гишүүн орнуудад өгсөн хяналт, шалгалтын стандарт, зөвлөмж, УИХ-аас батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Компанийн тухай хууль, Хорооноос баталсан дүрэм, журмуудыг хэрэгжүүлэх чиглэлээр газар дээрх болон зайны хяналт, шалгалтыг дараах хүрээнд авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Үнэт цаас гаргах, хувьцаат компанийн засаглал, тайлагналын ил тод байдлыг сайжруулах;
- Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, зах зээлийг урвуулан ашиглах үйлдлээс сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах;
- Мэргэжлийн оролцогч байгууллагуудад хууль тогтоомжийг мөрдүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны зохистой харьцааны болон стандартыг мөрдүүлэх;
- Хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд болон хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаанд хяналт тавих.

### Зайны хяналтын чиглэлээр

- 2016 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийсэн 153 ХК-ийн хурлын мэдэгдэл, материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж ажилласан;
- Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй нийт 85 ХК гарсан бөгөөд үүнд төрийн өмчит 30 ХК, "Анод банк", "Зоос банк", "Ай түүлс" зэрэг компаниуд багтсан байна. Хорооноос үлдсэн 52 ХК-ийг Компанийн тухай хуулийн 59.5-д зааснаар төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулахаас өөр бүрэн эрхгүй болсныг өөрийн www.frc.mn цахим хуудас болон "Монголын хөрөнгийн бирж" ХК, "ҮЦТХТ" ХХК-ийн цахим хуудаснуудаар тус тус олон нийтэд зарласан;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1, 56.2 дахь заалт, Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын 2.3.4.3, 2.3.4.4 дэх заалтуудын дагуу холбогдох мэдээллийг олон нийтэд мэдээлэх үүргийн хэрэгжилт хангалттай түвшинд хүрэхгүй байгаа тул хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор "ҮЦТХТ" ХХК-д Хорооны 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 51 дүгээр улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

### Газар дээрх хяналт шалгалтын чиглэлээр

- "Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо"-той хамтран 60 ҮЦК-д газар дээрх үзлэгийг 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 08-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв;
- Монголбанкны Ерөнхийлөгч, Хорооны даргын 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн хамтарсан тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ХБҮЦ гаргах тусгай зөвшөөрөл авахаар "Глашиер актив нэг" ХХК-аас Хороонд хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан Хасбанкны үйл ажиллагаанд хэсэгчилсэн газар дээрх шалгалтыг 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэв;
- "Монгол шуудан" ХК-ийн үйл ажиллагаанд мэргэжлийн хөрөнгө оруулагч болон жижиг хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах, компанийн удирдлагад тодорхой хэмжээнд оролцох хуулиар олгогдсон эрх зөрчигдөж байгаа тухай асуудалтай холбогдуулан хэсэгчилсэн хяналт, шалгалтыг 2016 оны 6 дугаар сарын 07-ны өдрөөс 2016 оны 6 дугаар сарын 09-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

# БҮЛЭГ 4

## ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ


### 4.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2016 оны 2 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны 1, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1, зуучлагч 39, хохирол үнэлэгч 30 компани зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 241 салбар, 10 төлөөлөгчийн газар, зуучлагч компанийн 201 салбар, хохирол үнэлэгч компанийн 49 салбар, 2 төлөөлөгчийн газар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу ажиллаж байна.

#### 4.1.1. Үйл ажиллагааны үзүүлэлтүүд

**Нийт актив:** Тайлант хугацаанд давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 201.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 30.8 тэрбум төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн. Үүнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХХК-ийн болон ердийн даатгалын компаниудын хөрөнгийн өсөлт голчлон нөлөөлсөн. Нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс өссөн ба өсөлтийн хувь нь сүүлийн 5 жилийн дундаж өсөлтөөс 6 пунктээр бага байна.

Дүрслэл 14. Ердийн ба урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгө (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөрөнгийн 52.1 хувийг хөрөнгө оруулалт эзэлж байгаа бөгөөд үүний 51.4 хувийг хадгаламжийн сертификат дангаар бүрдүүлж байна. Эх үүсвэрийн 54.6 хувийг нийт ер төлбөр, 45.4 хувийг эздийн өмчийн дүн тус тус эзэлж байна.

**Хураамжийн орлого:** Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын эхний хагас жилийн үзүүлэлтүүд 2011 оноос тасралтгүй өсөлттэй байсан бол 2016 оны 2 дугаар улиралд 61.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.9 тэрбум төгрөгөөр буюу 7.4 хувиар буурсан. Мөн ердийн болон урт хугацааны даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 7.1 ба 25.3 хувиар тус тус буурсан байна.

Дүрслэл 15. Ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын хураамжийн орлого (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгалд нийт 19.6 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь даатгалын хураамжийн нийт орлогын 32.1 хувьтай тэнцэв. Үүнээс “Бодь даатгал” ХХК,

“Мандал генерал даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК-ийн давхар даатгалд төлсөн хураамж нь 89.3 хувийг эзэлж байна.

Дүрслэл 16. Давхар даатгалд төлсөн хураамж




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

## 4.1.2 Даатгалын үйлчилгээний хүртээмж

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмжийг

илэрхийлдэг гол үзүүлэлтийн нэг бөгөөд 2015 оны жилийн эцсийн байдлаар дараах байдалтай байна.

Дүрслэл 17. Даатгалын нягтрал (төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


2015 оны жилийн эцэст нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 37,261.0 төгрөг байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.7 хувиар өссөн байна. Үүнийг даатгалын ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын

хураамж 36,721.0 төгрөг, урт хугацааны даатгалын хураамж 541.0 төгрөг байна. Эндээс урт хугацааны даатгалын хүртээмж нь ердийн даатгалаас тааруу байгааг илтгэж байна.

Дүрслэл 18. Даатгалын компани болон зуучлагчийн салбаруудын байршил аймаг, дүүргээр



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо



Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт болох даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо хангалттай болсон бөгөөд нэг аймагт дунджаар 14 даатгалын компани, зуучлагчийн салбар байна.

2016 оны нэгдүгээр улирлын байдлаар Улаанбаатар хотын нийт дүүрэгт даатгалын компани болон зуучлагчийн 128 салбар нэгж байсан бол тайлант хугацаанд 158 салбар нэгж болж өссөн. Монгол Улсын аймаг, дүүрэг бүрд даатгалын компанийн салбар, зуучлагчид үйлчилгээ үзүүлж байгаа боловч иргэдийн даатгалын үйлчилгээний тухай ойлголт бага, бичил даатгал болон урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилт муу байна.

#### 4.1.3 Даатгалын гүнзгийрэлт

Даатгалын салбарын эдийн засаг, санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг тооцохдоо гүнзгийрэлтийн түвшин / penetration/-г голчилдог ба 2016 оны 2 дугаар улирлын байдлаар салбарын хураамжийн орлого болон нийт хөрөнгийг нэрлэсэн ДНБ-д харьцуулахад 1.83, 0.56 хувийг тус тус эзэлж байна.

Энэхүү үзүүлэлтийг ердийн болон урт хугацааны даатгалын хэлбэрээр авч үзвэл урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь 0.005, 0.07, ердийн даатгалынх 0.55, 1.47 хувь байна.

Азийн хөгжлийн банкны судалгаанд дурдсанаар хөгжиж буй (emerging markets) зах зээлтэй орнуудын даатгалын салбарын гүнзгийрэлт дунджаар 2.98 хувь, дэлхийн дундаж 6.9 хувь байхад манай улсынх 0.98 хувь байгаа нь даатгалын салбарын хөгжил харьцангуй сул байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 17. Даатгалын гүнзгийрэлт

Он	Даатгалын салбарын гүнзгийрэлт		Ердийн даатгалын гүнзгийрэлт		Урт хугацаат даатгалын гүнзгийрэлт	
	Хураамжийн орлого/ДНБ	Нийт хөрөнгө /ДНБ	Хураамжийн орлого/ДНБ	Нийт хөрөнгө /ДНБ	Хураамжийн орлого/ДНБ	Нийт хөрөнгө /ДНБ
2011-II	0.40%	1.21%	0.40%	1.17%	0.002%	0.03%
2012-II	0.54%	1.26%	0.54%	1.22%	0.004%	0.05%
2013-II	0.49%	1.32%	0.49%	1.26%	0.006%	0.06%
2014-II	0.56%	1.34%	0.55%	1.28%	0.007%	0.06%
2015-II	0.62%	1.60%	0.61%	1.31%	0.007%	0.06%
2016-II	0.56%	1.83%	0.55%	1.47%	0.005%	0.07%

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын хөгжлийн үзүүлэлтийн 2016 оны 2 дугаар улирлын гүйцэтгэлийг үзэхэд, урт хугацааны даатгалын гүнзгийрэлт, нягтралыг ердийн даатгалын үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй бага түвшинд байна.

Иймд урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний ач холбогдол, өгөөжийг олон нийтэд сурталчлан таниулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын болон халамжийн зарим үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд шилжүүлэх, хувийн тэтгэврийн сангийн эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Ипотекийн эзэлдэгчийн амь насны даатгалын гэрээг урт хугацаат хэлбэрт шилжүүлэх;
- Гадаадын нэр хүнд бүхий урт хугацаат даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтын орчинг бүрдүүлэх;
- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх.

## 4.2. САЛБАРЫН БҮТЭЦ, ҮЙЛ ХӨДЛӨЛ

### 4.2.1 Салбарын бүтэц

Даатгалын салбарын бүтцийг илэрхийлэхдээ тухайн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг илэрхийлэгч үзүүлэлтүүдийг ашиглаалаа.

**Мэргэжлийн оролцогч:** Тайлант хугацаанд нийт 3,372 даатгалын компани, зуучлагч, төлөөлөгч, хохирол үнэлэгч, актуарч Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь 2015 оны жилийн эцсээс 319 оролцогчоор буурсан. Энэ бууралт хамгийн их нөлөө үзүүлсэн нь 320 даатгалын төлөөлөгчийн эрхийг хүчингүй болгосонтой холбоотой.

Хүснэгт 18. Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид

Он	Ердийн даатгал	Урт хугацааны даатгал	Давхар даатгал	Даатгалын компанийн салбар	Даатгалын төлөөлөгч	Даатгалын зуучлагч	Хохирол үнэлэгч	Актуарч	Нийт
2007	15	-	-	91	690	2	-	-	798
2008	15	1	-	120	1,167	4	-	9	1,316
2009	17	1	-	129	1,676	5	2	10	1,840
2010	16	1	-	138	2,061	9	6	12	2,243
2011	16	1	-	138	2,057	8	9	13	2,242
2012	17	1	-	188	2,357	17	9	18	2,607
2013	16	1	-	251	3,187	20	14	15	3,504
2014	16	1	-	247	3,260	30	20	15	3,589
2015	15	1	1	255	3,340	37	27	15	3,691
2016-II	15	1	1	251	3,020	39	30	15	3,372

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


**Салбарын эрэлтийг илэрхийлэгч үзүүлэлт:** Тайлант хугацаанд өссөн дүнгээр ердийн ба урт хугацааны даатгалын 541,279 гэрээ байгуулагджээ. Нийт гэрээний 473,681 буюу 87.5 хувь нь иргэнтэй, 67,548 буюу 12.5 хувь нь хуулийн этгээдтэй байгуулагдсан гэрээ юм. Салбарын хэмжээнд 16.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 25,800 хувь хүн, хуулийн этгээдэд олгосноос 25,799 ердийн даатгалаар олгогдсон байна.

**Салбарын нийлүүлэлтийг илэрхийлэгч үзүүлэлт:** Даатгалын байгууллагууд сайн дурын болон албан журмын даатгалын 2 төрлөөр нийт 23 даатгалын бүтээгдэхүүнийг хувь хүн, хуулийн этгээдэд санал болгож ажилласнаас 20 хэлбэрийн бүтээгдэхүүнийг 28,118.0 тэрбум төгрөгөөр үнэлж, 61.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг бүрдүүлжээ.

Нийт даатгасан зүйлийн үнэлгээний 26.7 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, 22.9 хувийг хөрөнгийн, 18.5 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал тус тус эзэлж байгаа бөгөөд дээрх 3 даатгалын хэлбэр нь нийт даатгалын зүйлийн 68.1 хувийг бүрдүүлж байна. Харин даатгалын компанийн хураамжийн орлогын 27.0 хувийг албан журмын, 32.3 хувийг хөрөнгийн, 13.3 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал тус тус эзэлж байна.

**Зах зээлд эзлэх хувь:** Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн 46.7 хувийг “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Мандал генерал даатгал” ХХК эзэлж байна. Иймд ердийн даатгалын салбарын зах зээл олигополи зах зээлийн шинжийг агуулсан байж болох юм.

Дүрслэл 19. Ердийн даатгалын компанийн зах зээлд эзлэх хувь




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

#### 4.2.2 Салбарын үйл хөдлөл

Салбарын оролцогчид зах зээлд бүтээгдэхүүн таниулах, сурталчлах, хэрэглэгчийн зан төлөвийг судлах чиглэлээр тодорхой хэмжээний борлуулалт, маркетингийн зардал

төлөвлөж, зарцуулдаг бөгөөд энэ нь тухайн салбарын үйл хөдлөлийг илэрхийлэх үзүүлэлт болдог. 2016 оны 2 дугаар улирлын хувьд 5.7 тэрбум төгрөгийг борлуулалт, маркетингийн үйл ажиллагаанд зарцуулжээ.

Дүрслэл 20. Ердийн даатгалын компаниудын борлуулалт, маркетингийн зардал



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

“Монгол даатгал” ХХК нь даатгалын салбарын нийт борлуулалт, маркетингийн зардлын хамгийн өндөр буюу 31.9 хувийг дангаар бүрдүүлж байгаа бол “Бодь даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК тус тус 14, 10.7, 10.7, 10 хувийг эзэлж байна.

#### 4.2.3. Даатгалын салбарын гүйцэтгэл

Салбарын хэмжээнд нийт орлогын хураамж өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар буурсан хэдий ч татварын дараах цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь компаниуд үйл ажиллагааныхаа зардлыг тайлант хугацаанд бууруулсантай холбоотой.



Даатгалын салбарын хөрөнгийн өгөөж (ХӨ) болон өөрийн хөрөнгийн өгөөж (ӨХӨ) нь компаниудын нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгөө ашиглан хэдий хэмжээний ашигт байдал бий болгож буйг илэрхийлэх бөгөөд энэ оны 2 дугаар улиралд ХӨ 2.4 хувь, ӨХӨ 4.7 хувь байна. Тайлант хугацаанд нийт салбарын ХӨ, ӨХӨ тус тус 1.1, 2.0 хувиар

өссөн. Даатгалын салбарын ХӨ болон ӨХӨ-ийн зохистой түвшинг тус тус харгалзан 0.5-1 хувь, 10-15 хувь байх ёстой гэж үздэг бөгөөд доорх хүснэгтээс харахад ердийн болон урт хугацааны даатгалын ХӨ өндөр боловч ӨХӨ бага үзүүлэлттэй байна.

#### Хүснэгт 19. Ашигт ажиллагаа

Он	Даатгалын салбарын ашигт ажиллагаа		Ердийн даатгалын ашигт ажиллагаа		Урт хугацааны даатгалын ашигт ажиллагаа	
	Хөрөнгийн өгөөж	Өөрийн хөрөнгийн өгөөж	Хөрөнгийн өгөөж	Өөрийн хөрөнгийн өгөөж	Хөрөнгийн өгөөж	Өөрийн хөрөнгийн өгөөж
2011	6.1%	12.9%	7.1%	17.2%	-7.5%	-8.9%
2012	3.9%	8.2%	4.1%	8.9%	-1.9%	-2.3%
2013	3.3%	7.0%	3.5%	7.7%	-1.0%	-1.2%
2014	1.1%	2.3%	1.1%	2.5%	0.3%	0.3%
2015	1.3%	2.7%	1.4%	3.1%	1.6%	2.0%
2016-II	2.4%	4.7%	2.2%	4.7%	1.1%	1.4%

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хохирол нөхөлтийн болон зардлын харьцаа, тэдгээрийн нийлбэр хосолсон харьцааг тодорхойлохдоо хөрөнгө оруулалтын орлогоос бус дан ганц үр ашигт менежментээс

шалтгаалах орлогоор тооцдог тул даатгалын салбарын ашигт ажиллагааг тодорхойлоход чухал үзүүлэлт болдог.

#### Хүснэгт 20. Даатгалын салбарын зардлын харьцаа

Он	Даатгалын салбар			Ердийн даатгал			Урт хугацааны даатгал		
	Хосолсон харьцаа	Хохирол нөхөлтийн харьцаа	Зардлын харьцаа	Хосолсон харьцаа	Хохирол нөхөлтийн харьцаа	Зардлын харьцаа	Хосолсон харьцаа	Хохирол нөхөлтийн харьцаа	Зардлын харьцаа
2011	90.0%	31.6%	58.4%	88.9%	31.8%	57.1%	190.7%	14.5%	176.2%
2012	94.9%	29.9%	65.0%	95.1%	30.1%	65.0%	84.5%	20.0%	64.4%
2013	106.2%	42.1%	64.1%	106.9%	42.7%	64.2%	77.1%	18.8%	58.3%
2014	109.5%	44.9%	64.6%	110.6%	45.4%	65.2%	70.1%	27.5%	42.6%
2015	111.3%	48.6%	62.7%	111.5%	48.5%	63.0%	101.7%	52.3%	49.3%
2016-II	98.5%	45.0%	53.5%	95.5%	44.5%	51.0%	145.2%	77.2%	68.1%

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хохирол нөхөлтийн харьцааг гаргахдаа учирсан хохирлыг орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцдог. Тайлант хугацаанд дээрх харьцаа ердийн даатгалын компаниудын хувьд 44.5, урт хугацааны даатгалын компанийн хувьд 77.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс ердийн даатгалынх 4.0 хувиар буурсан, харин урт хугацааны даатгалынх 24.8 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

Зардлын харьцааг тооцохдоо даатгалын компанийн үйл ажиллагааны зардлыг орлогод тооцсон нийт хураамжид харьцуулдаг бөгөөд ердийн даатгалын компаниудын хувьд 51.0 хувьтай байгаа бол урт хугацааны даатгалын компаниудын хувьд 68.1 хувьтай байна.

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хосолсон харьцаа 98.5 хувьтай гарсан нь нийт даатгалын салбарын үйл ажиллагааны зардал болон нөхөн төлбөрийн зардлын орлогод эзлэх хувь хэмжээ тун өндөр буйг харуулж байна. Даатгалын төрлөөр салгаж үзвэл урт хугацааны даатгалын хувьд орлогод тооцсон хураамж нь дээрх зардлуудыг нөхөж чадахгүй байна.

### 4.3. ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ

#### 4.3.1. Салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчин

2016 оны эхний хагас жилд Хорооны тогтоолоор “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”, “Даатгалын компанид мөрдөх дансны жагсаалт”, “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журам”, “Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-уудыг шинэчлэн батлаад байна. Цаашид хяналт, зохицуулалтын дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Урт хугацаат даатгалын бүтээгдэхүүн, ялангуяа ипотекийн зээлдэгчийн амь насны даатгалын гэрээг даатгалын зарчим, олон улсын практикийн дагуу урт хугацаат даатгалын хэлбэрт оруулах, түүний үйлчилгээний ач холбогдол, өгөөжийг олон нийтэд сурталчлан таниулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Даатгалын байгууллагуудын өөрийн эрсдэлийг үнэлэх, төлбөрийн чадварыг тооцох аргачлал нэвтрүүлэх (Own risk self assessment-ORSA);
- Даатгалын салбарын мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- Иргэдийн төлсөн даатгалын хураамжийг татвар ногдуулах орлогоос чөлөөлөх;
- Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх.

#### 4.3.2. Даатгуулагчдын эрх ашгийн хамгаалалт

Тайлант хугацаанд Хороонд даатгалын салбартай холбоотой 121 өргөдөл гомдол ирүүлснээс 114 өргөдлийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, 7 өргөдөл хянаж байна.

Хороонд жолоочийн хариуцлагын албан журмын, тээврийн хэрэгслийн, орон сууцны, зээлдэгчийн, хариуцлагын даатгалууд болон хохирол үнэлгээний тайлан, дүнг шалгуулах, Хорооноос баталсан дүрэм, журмыг хэрхэн ойлгох талаар ирүүлсэн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэж, 124.5 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг төлүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд нийт 121 өргөдөл, гомдол ирснээс “Бодь даатгал” ХХК нь 25 өргөдөл буюу нийт гомдлын 20 хувийг, “Миг даатгал” ХХК, “Мандал женерал даатгал” ХХК-иуд 15 өргөдөл буюу нийт гомдлын 12 хувийг тус тус эзэлж байна. 2016 оны 2 дугаар улиралд ирсэн өргөдөл, гомдлыг нэгдүгээр улиралд ирсэн өргөдөл, гомдолтой харьцуулахад харьцангуй бага байна.

Эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр ангилж харуулбал жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 35 хувь, тээврийн хэрэгслийн даатгал 26 хувийг эзэлжээ.

#### 4.3.3. Хяналт, шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга, хэмжээ

**Зайны хяналт:** 2016 оны 2 дугаар улиралд ердийн 15, урт хугацаат 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 38, даатгалын хохирол үнэлэгч 26 компани, албан журмын даатгагчдын холбоо 1, нийт 82 зохицуулалттай этгээдийн санхүүгийн тайлан болон нэмэлт тайланг хүлээн авч нэгтгэлээ.

Энэ улиралд даатгалын зуучлагч “Түвшин ориент” ХХК, даатгалын хохирол үнэлгээний “Жи Эй Си Си” ХХК, “Юу энд Эн” ХХК-уудын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээд байна.

**Газар дээрх хяналт шалгалт:** Эхний хагас жилийн байдлаар “Миг даатгал” ХХК, Албан журмын даатгагчдын холбоо, даатгалын хохирол үнэлгээний “Ашид билгүүн” ХХК-уудад газар дээрх хяналт шалгалт хийж, шалгалтын мөрөөр өгсөн үүрэг даалгаварт хяналт тавьж ажиллалаа.

**Шигтгээ 1:** Олон улсын даатгалын зохицуулагч, хяналтын байгууллагуудын холбоо 9 дэх жилийн ээлжит семинарыг 2016 оны 6 дугаар сард “Дэлхийн хэмжээнд тулгарч буй даатгалын асуудлууд” сэдвийн хүрээнд хэлэлцсэн байна. Уг семинараар холбооны гишүүд санхүүгийн тогтвортой байдалд хүрэх, даатгуулагчдыг хамгаалах зорилгодоо хүрэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг чухалчлах, даатгалын стандартыг хэрэгжүүлэхэд гишүүн орнуудыг идэвхтэй ажиллахыг уриалсан байна.

Семинарт оролцогчдоос даатгалын капиталын стандарт, системийн эрсдэл болон хөгжиж буй зах зээлтэй холбоотой дараах асуудлуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Системийн хэмжээнд ач холбогдол бүхий даатгалын компаниудад тавигдах капиталын стандартыг эрсдэлд суурилсан байдлаар шинэчлэн боловсруулах;
- Системийн хэмжээнд ач холбогдол бүхий даатгалын компаниудын үнэлгээний аргачлалыг сайжруулах;
- Тоон болон чанарын үзүүлэлтүүдийг ашиглан даатгалын компанийн түвшинд үйл ажиллагаанд суурилсан аргачлалаар системийн эрсдэлийг үнэлэх;
- Улс орны болон олон улсын түвшинд системийн ач холбогдолтой даатгалын компанийн ялгааг тодорхойлох;

- Хүртээмжтэй даатгалын салбарын талаарх дэлхийн хандлага, түүнд тохирсон хяналт шалгалтын сорилтуудыг хэлэлцэж, улс орнуудад тулгараад байгаа асуудлуудыг онцлон, шийдвэрлэх гарцыг олоход анхаарах;
- Бизнесийн ёс зүйн хяналтын талаарх олон төрлийн хандлагуудыг хэлэлцсэн. Тухайлбал, Канад улсын бизнесийн ёс зүйд тавих хяналт, Гана улсын гар утсаараа даатгалын үйлчилгээг авахад үүсэх эрсдэл, түүнийг бууруулах арга зам, Европын холбооны зохицуулалт, хяналт дахь бүтээгдэхүүний ил тод байдлын тоон болон чанарын үзүүлэлтүүдийг тэнцвэржүүлэх гэх мэт;
- Даатгалын гол зарчмуудын хэрэгжилтийг зохицуулалтын байгууллагууд үнэлж, зарчмын зөрүүтэй зүйлсийг илрүүлэх;
- Даатгалын кибер эрсдэлийн талаарх олон талт шинж чанаруудыг хэлэлцэж, эрсдэлийн зэрэглэлд хамаарагдах түүхэн мэдээллийн дутмаг байдал, кибер эрсдэлийн талаарх үг хэллэгийн нэгдмэл ойлголтгүй байгааг онцолжээ.

## БҮЛЭГ 5


# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

### 5.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2016 оны эхний хагас жилд Хорооны хуралдаанаар 53 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 4 банк бус санхүүгийн байгууллага / ББСБ/-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх

тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 499 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 21. ББСБ-уудын тоо




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Нийт актив:** Тайлант улиралд ББСБ-уудын нийт актив 676.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 122.0 тэрбум төгрөгөөр буюу 22.0 хувиар өссөн байна. 2016

оны хагас жилийн байдлаар нийт активыг нэрлэсэн ДНБ-д харьцуулахад 6.16 хувьтай гарлаа.

Дүрслэл 22. Нийт актив ба ДНБ



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Нийт активд эзлэх эргэлтийн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгийн харьцаа 96:4 бөгөөд үүнээс мөнгөн хөрөнгө 30.7 хувь, цэвэр зээл 56.0 хувь, бусад хөрөнгө 13.3 хувийг тус тус эзэлж байна.

Нийт активыг бүрдүүлэгч эх үүсвэрийн 25 хувийг өр төлбөр, 75 хувийг эздийн өмч эзэлж байна.


**ББСБ-уудын хүртээмжтэй байдал:** Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй 499 ББСБ-уудын 53 буюу 10.6 хувь нь хөдөө орон нутагт, 446 буюу 89.4 хувь нь хүн амын төвлөрлөө дагаад УБ хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

*Дүрслэл 23. Нэг ББСБ-д ногдох хүний амын болон ААН-ийн тоо*

Нэг ББСБ-д ногдох хүн амын тоо



Нэг ББСБ-д ногдох ААН-ийн тоо



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо Үндэсний статистикийн хороо

Хүртээмжтэй байдлыг тусгай зөвшөөрөлтэй ББСБ ба салбарын нийлбэр дүнг нийт хүн ам ба үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоонд тус тусад нь харьцуулах замаар тооцлоо. Улсын дундаж дүнгээр нэг ББСБ-д ногдох хүн амын тоо 4900, аж ахуй нэгжийн тоо 110 байна. Газарзүйн байршлаар авч үзвэл нэг ББСБ-д ногдох хүн амын тоо Улаанбаатар хотод 2605, аж ахуйн нэгж 81 байгаа ба улсын дүнгээс өндөр үзүүлэлттэй байна. Харин аймгийн бүсүүд дэх ББСБ-ийн тоо улсын дунджаас бага буюу аймгуудад үйлчилгээ үзүүлэх ББСБ-ын тоо цөөн байна. Ялангуяа Баруун бүс буюу Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудад ББСБ-ын үйлчилгээний хүртээмж бага байна.

Тайлант улиралд орон нутагт төвтэй ББСБ-уудын нийт хөрөнгө нь салбарын нийт хөрөнгийн 2.4 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь 3.1 хувь, эздийн өмч нь 2.8 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2.1 хувийг тус тус эзэлж байна.

**ББСБ-уудын үйл ажиллагааны үзүүлэлтүүд:** ББСБ-уудын нийт хөрөнгө өсч байгаа хэдий ч, тэдгээрээр үйлчлүүлэх харилцагчдын тоо буурч, нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ огцом өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 21. ББСБ-уудын санхүүгийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Огноо	Нийт хөрөнгө	Зээлийн өрийн үлдэгдэл	Нийт өр төлбөр	Эзэмшигчдийн өмч	Хоёрдогч өглөг	Цэвэр ашиг	Хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээл
2010	128.6	78.1	36.6	92	0.9	7.1	7.3
2011	205.4	119	67.2	138.2	2.7	11.4	7.6
2012	252.1	157.8	80.7	171.3	1.6	18.6	10.7
2013	381.1	223.7	146.8	234.3	1.6	29.8	18.6
2014	508.0	303.1	164.6	332.1	2.4	36.4	40
2015	623.1	391.2	175.6	424.2	1.4	46.3	52.7
2016-II	676.5	412.1	169.5	507.0	0.8	25.0	81.2

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

## 5.2. ББСБ-УУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 499 ББСБ-ын 28.4 хувь буюу 142 ББСБ гадаад валютын арилжаа эрхэлж байгаагаас 10.2 хувь буюу 51 нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байна. Нийт ББСБ-ын 88.8 хувь буюу 443 нь зээлийн үйл ажиллагаа, 6.6 хувь буюу 33 нь хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 3.2 хувь буюу 16 нь төлбөрийн

баталгаа гаргах, 5.6 хувь буюу 28 нь итгэлцлийн үйлчилгээ, 4.4 хувь буюу 22 нь факторингийн үйлчилгээ, 2.4 хувь буюу 12 нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.4 хувь буюу 2 нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлж байна.

Хүснэгт 22. ББСБ-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээ (давхардсан тоогоор)

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Давхардсан тоогоор	
		2015-II	2016-II
	Нийт ББСБ	423	499
1	Гадаад валютын арилжаа	131	142
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	52	51
	Зээл	361	443
3	Факторингийн үйлчилгээ	17	22
4	Төлбөрийн баталгаа гаргах	13	16
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	-	1
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	12
7	Итгэлцлийн үйлчилгээ	25	28
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	26	33

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

### 5.2.1. Зээл

Зээлийн үйл ажиллагаа явуулж буй 443 ББСБ-д тайлант улирлын байдлаар нийт 412.1 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл байгаагаас 330.9 тэрбум төгрөг буюу 80.3 хувийг хэвийн зээл, 49.1 тэрбум төгрөг буюу 11.9 хувийг чанаргүй зээл, 32.1 тэрбум төгрөг буюу 7.8 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус бүрдүүлж байна.

Нийт олгосон зээлийн хэмжээ 2015 оны 2 дугаар улирлаас 21.3 тэрбум төгрөг буюу 6.9 хувиар өссөн боловч нийт зээлд эзлэх чанаргүй зээл 72.9 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 31.9 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 23. Зээлийн бүтэц

№	Ангилал Дүн	2016-II		Өөрчлөлт (2015-II)	
		Хувь	Дүн	Хувь	Дүн
1	Хэвийн	330,895,909.5	80.3	21,285,241.9	6.9
2	Хугацаа хэтэрсэн	32,054,265.2	7.8	7,754,022.7	31.9
3	Чанаргүй зээл: Үүнээс	49,122,795.8	11.9	20,714,511.3	72.9
	Хэвийн бус	14,076,746.8	3.4	5,866,032.2	71.4
	Эргэлзээтэй	12,240,120.5	3	3,418,107.7	38.7
	Муу	22,805,928.5	5.5	11,430,371.4	100.5
4	(Зээлийн эрсдэлийн сан)	33,461,288.1	8.1	12,441,419.7	59.2
<b>Нийт зээл</b>		<b>412,072,970.5</b>	<b>100</b>	<b>49,753,775.9</b>	<b>13.7</b>
1	Үүнээс: Төгрөгөөр олгосон зээл	373,875,433.6	90.7	53,828,371.9	16.8
2	Гадаад валютаар олгосон зээл	38,197,536.9	9.3	(4,074,595.1)	(9.6)

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

### 5.2.2. Гадаад валютын арилжаа

2016 оны эхний хагас жилийн байдлаар гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд 22 төрлийн валют арилжиж 1.4 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

### 5.2.3. ББСБ-уудаас үзүүлж буй бусад үйлчилгээ

**Факторинг:** Факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 ББСБ-ын факторингийн тооцооны авлага 100.0 сая төгрөг болсноос 70.0 сая төгрөг буюу 70 хувь нь хэвийн, 30.0 сая төгрөг буюу 30 хувь нь муу авлагад ангилагдан 30.0 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

**Итгэлцлийн үйлчилгээ:** Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 28 ББСБ байгаагаас нэр бүхий 22 ББСБ 26.7

тэрбум төгрөгийг итгэмжлэн удирдаж байгаа нь салбарын нийт өр төлбөрийн 15.8 хувьтай тэнцэж байна.

### Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ:

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 12 ББСБ байгаагаас нэр бүхий 3 ББСБ-ын өрийн үлдэгдэл 3.0 тэрбум төгрөг байна. Энэ нь салбарын нийт өрийн 1.8 хувь, актив нь 40.1 тэрбум төгрөг байгаа нь салбарын нийт активын 5.9 хувь, эздийн өмчийн дүн 29.3 тэрбум төгрөг байгаа нь салбарын мөн үзүүлэлтийн 5.8 хувьтай тэнцэж байна.

**Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ:** Богино хугацаат хөрөнгө оруулалтад 1.3 тэрбум төгрөгийг байршуулснаас арилжааны үнэт цаасанд 6.9 хувь, хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 93.1 хувийг тус тус байршуулжээ.

Хүснэгт 24. Богино хугацаат хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)

№	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ	Эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	0.87	6.9%
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	1.2	93.1%
3	Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл, хямдруулалт	-	-
<b>Нийт</b>		<b>1.3</b>	<b>100.0%</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


Дээрх үйлчилгээний 89.0 хувийг 1 ББСБ дангаараа, үлдсэн 9.0 хувийг 4 ББСБ үзүүлсэн байна.

### 5.3. АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 25.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.1 тэрбум төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн байна. Нийт ББСБ-ын 73.1 хувь буюу 365 ББСБ 28.6

тэрбум төгрөгийн ашигтай, 18.6 хувь буюу 93 ББСБ 3.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, 8.2 хувь буюу 41 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.

Дүрслэл 24. Ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд 406 ББСБ буюу нийт ББСБ-ын 80 хувь нь 21.5 тэрбум төгрөгийн ашигтай, 93 ББСБ буюу нийт ББСБ-уудын 19 хувь нь 3.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тэнцлийн гадуурх дансны нийт үлдэгдэл 448.7 тэрбум төгрөг байгаагаас үнэ бүхий зүйл 410.5 тэрбум төгрөг, зээл болон бусад хөрөнгийн тооцооны үлдэгдэл 3.5 тэрбум төгрөг байна.



Дүрслэл 25. Нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгийн өгөөж



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


ББСБ-уудын нийт хөрөнгийн ба өөрийн хөрөнгийн өгөөж 2016 оны эхний хагас жилд 5.7, 4.1 хувь гарч, өнгөрсөн оны мөн үеэс 0.8, 0.1 хувиар тус тус буурсан байна.

### 5.3.1. Орлогын бүтэц

Тайлант улиралд ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

ББСБ-уудын үндсэн үйл ажиллагааны буюу хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар өсч, нийт орлогын 77.8 хувийг эзэлж байна. Харин хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар буурч, нийт орлогын 20.4 хувийг эзэлж байгаа ба нийт орлогын дүнд эзлэх үндсэн бус үйл ажиллагааны орлого өмнөх оны мөн үеэс 93.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 26. Хүүгийн ба хүүгийн бус орлого




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 75.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 15.9 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байгаа бол тайлант улиралд нийт хүүгийн бус орлогын 8.3 хувийг гадаад валютын арилжааны орлого, 65.0 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 26.7 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого тус тус эзэлж байна.

### 5.3.2. Зарлагын бүтэц

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар, үүний дотор хүүгийн зардал 9.9 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 30.1 хувиар, орлогын татварын зардал 18.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 22.9 хувиар тус тус өсч, хүүгийн бус зардал 1.7 хувиар буурсан бөгөөд тайлант хугацаанд нийт 25.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.5 хувиар өссөн үзүүлэлт юм.

Дүрслэл 27. Зардлын бүтэц



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

## 5.4. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг

тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон шалгуур үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

### 5.4.1. Валют арилжааны ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 25. Валют арилжааны зохистой харьцаа

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	45	88.2
2	Зохистой харьцааны 1 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	5.9
3	Зохистой харьцааны 2 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	5.9
4	Зохистой харьцааны 3 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
5	Зохистой харьцааны 4 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
6	5 ба түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
<b>Нийт</b>		<b>51</b>	<b>100.0</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Валют арилжааны ББСБ-ын тооцвол зохих 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

- Нийт өөрийн хөрөнгө 12.3 тэрбум төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 8.3 тэрбум төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 94.4 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлага 92.6 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
- Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 300.0 сая төгрөг, нийт актив 15.6 тэрбум төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 96.3 хувиар;
- Өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тус тус бүрэн хангасан байна.

#### 5.4.2. Зээл санхүүжилтийн ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 26. Зээл санхүүжилтийн зохистой харьцаа

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	271	68.4
2	Зохистой харьцааны 1 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	80	20.2
3	Зохистой харьцааны 2 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	34	8.6
4	Зохистой харьцааны 3 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	7	1.8
5	Зохистой харьцааны 4 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	0.8
6	5 ба түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.3
<b>Нийт</b>		<b>396</b>	<b>100.0</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Зээл санхүүжилтийн ББСБ-ын тооцвол зохих 14 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

- Нийт өөрийн хөрөнгө 340.3 тэрбум төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 647.1 тэрбум төгрөг байгаа нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 94.7 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 94.4 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 99.0 хувиар;
- Нийт түргэн борлогдох актив 119.8 тэрбум төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 52.9 тэрбум төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 97 хувиар;
- Нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 87.8 хувиар;
- Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 13.9 тэрбум төгрөг, нийт актив 393.3 тэрбум төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 94.2 хувиар;
- Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 99.5 хувиар тус тус хангасан байна.

#### 5.4.3. Хөрөнгө удирдлагын ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 27. Хөрөнгө удирдлагын зохистой харьцаа

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	34	70.8
2	Зохистой харьцааны 1 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	9	18.8
3	Зохистой харьцааны 2 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	4.2
4	Зохистой харьцааны 3 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	4.2
5	Зохистой харьцааны 4 шалгуурыг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	2.1
6	5 ба түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
<b>Нийт</b>		<b>48</b>	<b>100.0</b>

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

- Нийт өөрийн хөрөнгө 154.4 тэрбум төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 213.4 тэрбум төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага бүрэн, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 97.9 хувиар;
- Нийт түргэн борлогдох актив 74.3 тэрбум төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 109.5 тэрбум төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 91.7 хувиар;
- Нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 91.6 хувиар;
- Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 26.7 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 154.4 тэрбум төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 80 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
- Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 11.8 тэрбум төгрөг, нийт актив 267.7 тэрбум төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 91.6 хувиар;
- Гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 154.4 тэрбум төгрөг байгаагаас хаалттай өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 50 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
- Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг тус тус бүрэн хангаж ажилласан байна.

## БҮЛЭГ 6


# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

### 6.1. ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

**Нийт актив:** Тайлант хугацааны хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/-дын нийт активын нэрлэсэн ДНБ-д эзлэх хэмжээ 0.96 хувьд хүрсэн бөгөөд өнгөрсөн оны мөн

үетэй харьцуулахад 0.16 хувиар өсчээ. Нийт активын хэмжээ 105.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.1 хувиар өсөөд байна.

Дүрслэл 28. Хадгаламж, зээлийн хоршоодын актив




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**Зээлийн үзүүлэлт:** ХЗХ-дын нийт зээлийн хэмжээ 81.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.6 хувиар өссөн. ХЗХ-дын нийт зээлийн хэмжээ өсөхөд ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үеэс 35-аар

буюу 14.5 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Эхний хагас жилийн ДНБ-д эзлэх нийт зээлийн хэмжээ 0.74 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.07 хувиар өслөө.

Дүрслэл 29. ХЗХ-дын нийт зээлийн чанар (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нийтдээ 4.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 73.2 хувиар, нийт чанаргүй зээлийн хэмжээ 77.5 хувиар тус тус өссөн байна.

**Хадгаламжийн үзүүлэлт:** 2016 оны эхний хагас жилийн байдлаар ХЗХ-дын нийт хадгаламжийн хэмжээ 63.6 тэрбум

төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар өссөн. Эхний хагас жилийн ДНБ-д эзлэх хадгаламжийн хэмжээ 0.6 хувьд хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.06 хувиар өссөн байна.

Дүрслэл 30. ХЗХ-дын нийт хадгаламж (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ нийт эх үүсвэрийн 60.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 61.1 тэрбум төгрөг буюу 96.2 хувь нь хугацаатай хадгаламж бол 3.8 хувь нь хугацаагүй хадгаламж байлаа. Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт 277 ХЗХ-дын гишүүдийн тоо 43,755-д хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 8,449 гишүүнээр нэмэгдсэн байна.

**Өр төлбөр, өөрийн хөрөнгө:** Эхний хагас жилд ХЗХ-дын хоршоологчдын өмч 10.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2 хувиар өссөн. ХЗХ-дын хувь хөрөнгө 11.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар, нийт өр төлбөрийн хэмжээ 19.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 58.1 хувиар тус тус өсөлттэй гарлаа.


Дүрслэл 31. ХЗХ-дын өөрийн хөрөнгө, өр төлбөр (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**ХЗХ-ны үйлчилгээний хүртээмж:** Тайлант хугацаанд нийт 277 ХЗХ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд 65 хувь нь Улаанбаатар хотод, 35 хувь нь орон нутагт ажиллаж байна.

Дүрслэл 32. ХЗХ-дын тоо (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

**ХЗХ-ны үр ашигт байдал:** ХЗХ-дын нийт орлого 11.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.52 тэрбум төгрөг буюу 14.7 хувиар өссөн бол нийт зардал өмнөх оны мөн үеийнхээс 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

Ингэснээр нийт ашиг 1.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 14.3 хувиар өссөн байна. Тайлант улиралд нийт хоршооны 60 хувь нь ашигтай, 7 хувь нь ашиг, алдагдалгүй, 33 хувь нь алдагдалтай ажиллав.

Дүрслэл 33. ХЗХ-дын ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Мөн эдийн засгийн өсөлт саарч байгаатай холбоотойгоор ХЗХ-дын гишүүдийн орлогын эх үүсвэр тасалдах, буурах зэрэг хүчин зүйлс чанаргүй зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлж, олгогдсон зээл хугацаандаа төлөгдөхгүй байх нөхцөл үүсч байгаа тул ХЗХ-дод тавигдах шалгуурыг өндөрсгөх, тэдгээрийг чадавхижуулах, хяналт шалгалтын оновчтой бодлого хэрэгжүүлэхэд анхаарах нь зохистой.

**Шигтгээ 1:** Хадгаламж, зээлийн хоршоодын олон улсын холбооноос /WOCCU/ гаргасан 2015 оны жилийн эцсийн тайлан мэдээгээр дэлхийн хэмжээнд 109 орны 223,000,000 гишүүнтэй 60,500 хадгаламж, зээлийн хоршоод үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр хадгаламж, зээлийн хоршоодын нийт актив 1,823.0 тэрбум ам.доллар, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж нь 1,507.9 тэрбум ам.доллар, нийт зээлийн үлдэгдэл 1,242.4 тэрбум ам.доллар байна.

## 6.2. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХЗХ-ны салбарын хэмжээнд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд ХЗХ-доос 2016 оны 2 дугаар улирлын байдлаар Хороонд ирүүлсэн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн тайлан, санхүүгийн тайлан болон тоон мэдээлэлд үндэслэн олон улсын зөвлөхийн өгсөн зөвлөмжийн дагуу санхүүгийн тайлангийн гол харьцаа алдагдсан ХЗХ-д дараах байдалтай байна.

Хүснэгт 28. Зохистой харьцаа

№	Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд	ХЗХ-дын тоо	ХЗХ-дод эзлэх хувь
1	Чанаргүй зээл харьцаа алдагдсан	47	16.9
2	Активын өгөөж буурсан	90	32.4
3	Хадгаламжийн бууралттай	35	12.6
4	Өөрийн хөрөнгөгүй	17	6.1
5	Зээл, хадгаламжийн харьцаа алдагдсан	16	5.7
6	Зээл хүү төлдөг эх үүсвэрийн харьцаа алдагдсан	28	10.1

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй нийт 277 ХЗХ-оос чанаргүй зээлийн харьцаа өндөр 47, активын өгөөж буурсан 90, хадгаламжийн хэмжээ буурсан 35, зээл болон хадгаламжийн харьцаа алдагдсан 16, зээл болон хүү төлдөг эх үүсвэрийн харьцаа алдагдсан 28, өөрийн хөрөнгөгүй болсон 17 байна.

## 6.3. ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

### 6.3.1. Салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчин

Монгол Улсын Их Хурлаас 2011 онд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг зохицуулсан, хөгжлийг дэмжсэн бие даасан хуулийг баталсан. Энэ хуулиар ХЗХ нь хадгаламж болон зээлийн үйл ажиллагаанаас гадна санхүүгийн бусад ажил үйлчилгээг эрхлэх боломжтой болж, гишүүдийнхээ хадгаламжийг эрсдэлээс хамгаалах, баталгаажуулах зорилго бүхий даатгалын систем болон тогтворжилтын сангийн харилцааг тусгаж өгсөн.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасны дагуу Хороо хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон холбогдох зохицуулалтын бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдүүлэн ажиллаж байна.

ХЗХ-ны салбарын хөгжлийг дэмжих, гишүүдэд хүргэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ХЗХ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхээс гадна санхүүгийн түрээсийн үйлчилгээ, төслийн санхүүжилт, цахим төлбөр тооцооны төлөөлөгч, даатгалын төлөөлөгч, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, хуримтлалын сан үүсгэх, удирдах зэрэг санхүүгийн үйлчилгээг эрхлэх боломжтой болсон.

Хорооноос ХЗХ-ны салбарын бодлого, зохицуулалтын орчинг боловсронгуй болгох хүрээнд хоёр журам, нэг жагсаалтаар журамлаж байсан зохицуулалтыг нэгтгэн нэг журмаар зохицуулж, салбарыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн хороодод "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-т хамрагдсан ХЗХ-дын үйл ажиллагаанд мөрдүүлэх зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоосон.

Хороо нь төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодлогын хүрээнд МХЗХҮХ-ны гишүүн 300,0 сая төгрөгөөс доош активтай ХЗХ-ны Хороонд жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг бүрэн чөлөөлж, Холбооны гишүүн бусад ХЗХ нь жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийг хөнгөлсөн.

### 6.3.2. Салбарын бодлого

ХЗХ-ны салбарын тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн түвшинг тодорхойлох, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гишүүдэд хүргэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бодлогын арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр ХЗХ-ны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах асуудлыг танилцуулан, шийдвэрлэх;
- Салбарын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилго бүхий тогтворжилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх;
- ХЗХ-дыг орлогын албан татвараас чөлөөлүүлэх асуудлыг шийдвэрлэх, олсон орлогыг гишүүдийн амьжиргаа, нийгмийн үйл ажиллагаанд зарцуулах боломжийг бүрдүүлэх;
- ХЗХ-ны үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах зорилгоор хоршоодоос олгож байгаа зээлийн талаарх мэдээллийг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах;
- ХЗХ-дын барьцаа хөрөнгө дутагдалтай жижиг, дунд бизнес эрхэлж буй гишүүдэд олгох зээлийг Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах.


## БҮЛЭГ 7

# ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН


Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль 2012 онд батлагдаж, төрийн өмчит сан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн

орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий уг сан нь 2014 оны 3 дугаар улирлаас эхлэн хуулийн этгээдэд зээл олгож эхэлсэн ба өнөөдрийн байдлаар 55.4 тэрбум төгрөгийн зээлд, 23.9 тэрбум төгрөгийн батлан даалтыг 240 хуулийн этгээдэд олгоод байна.

Дүрслэл 34. Батлан даалтын тоо



Дүрслэл 35. Батлан даалт олгосон хэмжээ (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Зээлийн батлан даалтын сан

Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах тоо буурсан ба үүнийг дагаад олгосон батлан даалтын хэмжээ мөн багасжээ. 2015 оны 2 дугаар улиралд 42 зээлд батлан даалт гаргасан бол энэ оны 2 дугаар улиралд 21 батлан даалт гаргасан нь 2015 оны мөн үеэс 50 хувиар буурсан байна.

2014 оноос хойш олгосон нийт батлан даалтыг хүртээмжээр буюу газарзүйн байршлаар нь харвал Улаанбаатар хотод 19.3 тэрбум төгрөг буюу 80.7 хувь, Төвийн бүсэд 2.9 тэрбум төгрөг буюу 12.1 хувь, Баруун бүсэд 679.9 сая төгрөг буюу 2.8 хувь, Хангайн бүсэд 589.5 сая төгрөг буюу 2.5 хувь, Зүүн бүсэд 449.5 сая төгрөг буюу 1.9 хувийг тус тус олгосон байна.

Хүснэгт 29. Олгосон батлан даалтын тоо, хэмжээ

Газарзүйн байршил	Батлан даалтын тоо	Батлан даалтын хэмжээ (сая төгрөг)	Батлан даалтын хэмжээ /хувиар/
Баруун бүс	16	679.9	2.8%
Хангайн бүс	24	589.5	2.5%
Төвийн бүс	33	2,903.8	12.1%
Зүүн бүс	11	449.5	1.9%
Улаанбаатар хот	156	19,296.1	80.7%
<b>Нийт</b>	<b>240</b>	<b>23,918.8</b>	<b>100.0%</b>

Эх үүсвэр: Зээлийн батлан даалтын сан

Улаанбаатар хот болон төвийн бүсэд олонх батлан даалтыг олгосон нь хүн ам болон үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжийн төвлөрөлтэй холбоотой. Учир нь нийт үйл ажиллагаа явуулж аж ахуй нэгжийн тоо 2016 оны 2 дугаар улирлын байдлаар 68,425 байгаа ба үүний 63.6 хувь нь

Улаанбаатар хотод, 11.9 хувь нь төвийн бүсэд, 11.0 хувь нь хангайн бүсэд, 9.2 хувь нь баруун бүсэд, 4.3 хувь нь зүүн бүсэд тус тус байршиж байна.